

# СҮРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХУЙ

Шинэчлэн найруулсан 7 дахь хэвлэл



## 1. СҮРЬЕЭГИЙН СЭЖИГТЭЙ ХҮМҮҮСИЙГ ИЛРҮҮЛЭХ

Халдвартай хэлбэрийн сүрьеэгээр өвчилсөн хүн нийт хүн амын дунд сүрьеэгийн халдвар тараах эх уурхай болдог. Тэднийг эрт оношлож бүрэн төгс эмчилснээр сүрьеэ өвчин тархах замыг таслан зогсооно.

Сүрьеэ өвчин ихэвчлэн уушгийг гэмтээх ба уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэтэй хүний ярих, ханиах, найтаахад халдвар тархдаг тул цэрийг шинжлэх нь оношлогооны гол арга болдог. 2 долоо хоногоос дээш ханиалгаж буй хүнийг сүрьеэгийн сэжигтэй тохиолдол гэж тооцно.


Ханиалгах нь уушгины сүрьеэгийн үед илрэх гол шинж тэмдэг юм. Үүнээс гадна:

- Цэр, цустай цэр гарах
- Турах
- Халуурах
- Хөлрөх
- Цээжээр өвдөх шинж тэмдэг илэрнэ.
- Уушгины бус эрхтэний сүрьеэгийн үед ерөнхий хордлогын шинж тэмдгээс

гадна аль эрхтэн гэмтсэнээс шалтгаалсан өвөрмөц шинж тэмдгүүд гарна.

Дээрх шинж тэмдэг зовиур илэрч буй өвчтөнийг сум, өрхийн эмч “Уушгины эмгэгтэй хүмүүсийг илрүүлэх бүртгэл” ТВ-15 маягтад бүртгэж зохих шинжилгээнд хамруулна.

**СҮРЬЕЭГИЙН СЭЖИГТЭЙ ӨВЧТӨНТЭЙ ХАРЬЦАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**



Эрүүл мэндийн сайдын 2009 оны ..11... сарын.20..  
өдрийн 397..тоот тушаалаар батлав.  
**ТХТ-1**

**УУШИГНЫ ЭМГЭГТЭЙ ХҮМҮҮСИЙГ ИЛРҮҮЛЭХ БҮРТГЭЛ ТВ-15**

| Cap өдөр | № | Эцэг(эх)-ийн нэр,<br>Нэр   | Нас, хүйс | Тогтмол хаяг                 | Ажлын<br>газар | Түрхэцийн шинжилгээ     |        |     |                              | Цээжний зургийн<br>шинжилгээ |          |            | Туберку-лины<br>сорил |                       | Онош                         | Тайлбар  |
|----------|---|----------------------------|-----------|------------------------------|----------------|-------------------------|--------|-----|------------------------------|------------------------------|----------|------------|-----------------------|-----------------------|------------------------------|----------|
|          |   |                            |           |                              |                | Шинжилгээ өгсөн<br>онго | I      | II  | Шинжилгээнд<br>явуулсан онго | Огноо                        | Явуулсан | Авахуулсан | Шинжлэгний харуу      | Сорил тавьсан<br>онго |                              |          |
| 1        | 2 |                            | 4         | 5                            | 6              | 7                       | 8      | 9   | 10                           | 11                           | 12       | 13         | 14                    | 15                    | 16                           | 17       |
| III-4    | 1 | Туул Өсөхбаяр              | 28 эм     | СХД 23 хороо<br>Хангай 44-24 | ажилгүй        | III-4                   | III-5  | 2+  | 2+                           |                              |          |            |                       |                       | Инфильтративный<br>ТВ легких | Gr 23-24 |
| III-10   | 2 | Энхтүвшин<br>Ууганцэцэг    | 26 эм     | СХД 23 хороо<br>47-21        | оператор       | III-10                  | III-12 | сөр | сөр                          |                              |          |            |                       |                       | Онош тодруулах               |          |
| IV-1     | 3 | Чимэдцэрэн<br>Батмөнх      | 31 эр     | СХД 23 хороо<br>69б-16       | ажилгүй        | IV -1                   | V-5    | 1+  | сөр                          |                              |          |            |                       |                       | Инфильтративный<br>ТВ легких |          |
| V-3      | 4 | Үнэнсайхан<br>Сайханбаатар | 40 эр     | СХД 23 хороо<br>Х-20-9       | мужаан         | V-3                     | V-4    | сөр | сөр                          |                              |          |            |                       |                       | Онош тодруулах               |          |
| V-13     | 5 | Жаламсүрэн<br>Баттуул      | 26 эм     | СХД 23 хороо<br>Х-28-10      | ажилгүй        | V-13                    | V-14   | сөр | сөр                          |                              |          |            |                       |                       | Онош тодруулах               |          |
| V-19     | 6 | Явра Хадбаатар             | 33 эр     | СХД 23 хороо<br>Х-80-10      | группт         | V-19                    | V -20  | сөр | сөр                          |                              |          |            |                       |                       | Онош тодруулах               |          |
| VI-4     | 7 | Шийлэгбаатар<br>Жаргал     | 58 эр     | СХД 23 хороо<br>Х-60-13      | тэтгэвэрт      | VI-4                    | VI-5   | сөр | сөр                          |                              |          |            |                       |                       | Онош тодруулах               |          |

## Уушигны эмгэгтэй хүмүүсийг шинжилгээнд хамруулах

Сум, өрхийн эмч сүрьеэгийн сэжигтэй тохиолдлыг “Уушгины эмгэгтэй хүмүүсийг илрүүлэх бүртгэл”-д зовиур, өвчний шинж тэмдэгийг үндэслэн бүртгэж авсаны дараа “Өвчтөн илгээх хуудас”-ыг дараах байдлаар бөглөж аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерт илгээнэ.

Эрүүл мэндийн сайдын 2009 оны .11... сарын .20  
өдрийн .397..тоот тушаалаар батлав.

**ТХТ-2**

### Өвчтөн илгээх хуудас

Эмнэлгийн нэр \_\_\_\_\_ Гурван жаргал хайрхан өрхийн эмнэлэг \_\_\_\_\_

|  |  |  |  |  |  |  |
|--|--|--|--|--|--|--|
|  |  |  |  |  |  |  |
|--|--|--|--|--|--|--|

Өвчтөний эцэг/эх/-ийн нэр, Нэр Туул Өсөхбаяр  
 РД УТ 83072561 Нас 28 Хүйс: Эрэгтэй, Эмэгтэй  
 Тогтмол хаяг СХД 23 хороо Хангай 44-24  
 Утасны дугаар 88994662

Заалт: ( + ) Цэрний шинжилгээ  
 ( ) Шууд хяналттай эмчилгээ  
 ( ) Бусад \_\_\_\_\_

Илгээх байгууллагын нэр СХД-ийн сүрьеэгийн диспансер  
 Эмчийн гарын үсэг Оюунгэрэл / Оюунгэрэл /

Он 2010 сар 3 өдөр 4

## 2. СҮРЬЕЭТЭЙ ӨВЧТӨНГ ОНОШЛОХ

### Эмчилгээний өмнөх цэрний шинжилгээний хариуг тэмдэглэх Цэрний шинжилгээний хуудас (ТВ 05)

Сүрьеэгийн сэжигтэй хүнээс 24 цагийн дотор 2 удаа цэрийг авч шинжилгээ хийнэ. Эхний сорьцыг эмнэлэгт анх ирэхэд авч, өглөөний өлөн цэр буюу 2 дахь сорьцыг цуглуулах сав өгч явуулаад өглөө сорьцны чанарыг шалгаж хүлээн авна. Сорьц өгүүлэхээр илгээж буй эмч, эмнэлгийн ажилтан “Цэрний шинжилгээний хуудас”-ны:

- Эмнэлгийн нэр
- Он сар өдөр
- Өвчтөний овог нэр
- Нас, хүйс
- Оршин суугаа хаяг
- Өвчний ангилал
- Шинжилгээний зорилго хэсгүүдийг бөглөн лабораторт илгээнэ.

Сорьцыг хүлээн авсан лаборант, эмнэлгийн ажилтан:

- Шинжилгээ өгсөн он сар өдөр
- Хүлээн авсан хүний гарын үсэг хэсгийг бөглөнө.

Шинжилгээ хийсэн лаборант:

- Шинжилгээний дугаар
- Цэрний шинж
- Шинжилгээний хариу
- Он сар өдрийг шинжилгээний хариуг тэмдэглэсэн “Лабораторийн шинжилгээний бүртгэл” ТВ-04-г үндэслэн бичиж ирүүлсэн эмнэлэгт явуулна.

### Цэрний шинжилгээний хуудас

Эмнэлгийн нэр\_\_СХД 23 хорооны өрхийн эмнэлэг\_\_ он 2010 сар 03 өдөр 05

Өвчтөний овог, нэр\_\_Туулын Өсөхбаяр\_\_ нас\_28\_ хүйс эр  эм

Оршин суугаа хаяг\_\_СХД-ийн 23-р хороо Хангайн 44-24\_\_\_\_\_

Өвчний ангилал: уушгины  уушгины бус эрхтний

Шинжилгээний зорилго: оношлогоо  эмчилгээний хяналт

Шинжилгээний дугаар хяналтын картын дугаар

Шинжилгээ өгсөн \_\_\_\_\_ Хүлээн авсан хүний \_\_\_\_\_

Он сар өдөр\_\_\_\_\_ гарын үсэг\_\_\_\_\_

### Шинжилгээний хуудас

Шинжилгээний дугаар\_\_\_\_\_

а/ цэрний шинж: өтгөн  цусархаг  шүлс  салст идээт

б/ бичил харах аргаар:

| Он, сар, өдөр | Түрхэц | Хариу* | Эерэг                    |                                     |                          |                          |
|---------------|--------|--------|--------------------------|-------------------------------------|--------------------------|--------------------------|
|               |        |        | +++                      | ++                                  | +                        | +-(1-2)                  |
| III-5         | 1      | ээрэг  | <input type="checkbox"/> | <input checked="" type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| III-5         | 2      | ээрэг  | <input type="checkbox"/> | <input checked="" type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
|               | 3      |        | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/>            | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

\*ээрэг эсвэл сөрөг гэж бичнэ.

Он, сар, өдөр\_\_III-5\_\_\_\_\_ Шалгасан хүний гарын үсэг\_\_\_\_\_ Оюунтунгалаг \_\_\_\_\_

Хуудсыг бөглөөд ирүүлсэн эмнэлэгт явуулна.

### Лабораторийн шинжилгээний бүртгэл (ТВ 04)

Тус бүртгэлийг лабораторт түрхэцийн шинжилгээний хариуг бичихэд хөтөлнө. ТВ-04 маягтанд дараах мэдээллийг тэмдэглэнэ.

- Лабораторийн цувралын дугаар: тайлангийн жилийн эхнээс давхардуулахгүй дугаарлана.
- Сар өдөр: шинжилгээ хийсэн он сар өдрийг тэмдэглэнэ.
- Овог нэр, нас хүйс, гэрийн хаяг: овог нэр, гэрийн хаягийг дэлгэрэнгүй бүрэн бичнэ.
- Шинжилгээнд явуулсан газар: аймаг дүүргийн диспансер, өрх сумын эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлгийн нэрийг тодорхой бичнэ.

- Шинжилгээний зорилго: Цэрний шинжилгээний хуудас (ТВ 05)-д сүрьеэгийн сэжигтэй тохиолдолд хийж байгаа буюу оношлогооны эсвэл эмчилгээний хяналтын шинжилгээ болохыг илгээсэн эмчийн тэмдэглэгээнээс харна.
- Шинжилгээний хариу: Цэрний түрхэцийн шинжилгээг дүгнэхдээ бэлдсэн түрхэцнээс 100 харах талбайг (ХТ)-г уншаад түүнд илэрсэн хүчилд тэсвэртэй нянгийн (ХТН) тоогоор дүгнэнэ.

|              |                           |
|--------------|---------------------------|
| (0)          | ХТН олдоогүй / 100 ХТ     |
| (тоог бичнэ) | 1-9 ХТН / 100 ХТ          |
| (+)          | 10-99 ХТН / 100 ХТ        |
| (++)         | 1-10 ХТН / 50 ХТ бүрт     |
| (+++)        | 10 дээш ХТН / 200 ХТ бүрт |
- 2 сорьцын хариуг тус бүр тэмдэглэн шинжилгээ хийж тэмдэглэл хөтөлсөн лаборант гарын үсгээ зурна.



Лабораторийн шинжилгээний бүртгэл 2010 он

| Лаб цувралын дугаар | Сар өдөр | Овог нэр      | Хүйс | Нас | Шинжилгээнд явуулсан газар           | Гэрийн хаяг               | Шинжилгээний зорилго |                    | Шинжилгээний харуу |    |    | Батлагдсан байдал |    |   | Гарын үсэг    |
|---------------------|----------|---------------|------|-----|--------------------------------------|---------------------------|----------------------|--------------------|--------------------|----|----|-------------------|----|---|---------------|
|                     |          |               |      |     |                                      |                           | * Оюунлог            | ** Эмчилгээ хяналт | 1                  | 2  | 3  | 1                 | 2  | 3 |               |
|                     |          |               |      |     |                                      |                           |                      |                    |                    |    |    |                   |    |   |               |
| 435                 | III-5    | Туул Өсөхбаяр | эм   | 28  | Гурван жаргал хайрхан өрхийн эмнэлэг | СХД 23 хороо Хангай 44-24 | +                    | Эмчилгээ хяналт    | 2+                 | 2+ | 2+ | 2+                | 2+ | 3 | Оюунтуунаалаг |
|                     |          |               |      |     |                                      |                           |                      |                    |                    |    |    |                   |    |   |               |
|                     |          |               |      |     |                                      |                           |                      |                    |                    |    |    |                   |    |   |               |
|                     |          |               |      |     |                                      |                           |                      |                    |                    |    |    |                   |    |   |               |
|                     |          |               |      |     |                                      |                           |                      |                    |                    |    |    |                   |    |   |               |
|                     |          |               |      |     |                                      |                           |                      |                    |                    |    |    |                   |    |   |               |
|                     |          |               |      |     |                                      |                           |                      |                    |                    |    |    |                   |    |   |               |
|                     |          |               |      |     |                                      |                           |                      |                    |                    |    |    |                   |    |   |               |
|                     |          |               |      |     |                                      |                           |                      |                    |                    |    |    |                   |    |   |               |
|                     |          |               |      |     |                                      |                           |                      |                    |                    |    |    |                   |    |   |               |
|                     |          |               |      |     |                                      |                           |                      |                    |                    |    |    |                   |    |   |               |
|                     |          |               |      |     |                                      |                           |                      |                    |                    |    |    |                   |    |   |               |

\* ШИНЭ ЭСВЭЛ ДАХИЛТ ГЭЖ ТЭМДЭГЛЭНЭ. \*\* ЭМЧИЛГЭЭ ХИЙГДЭЖ БАЙГАА ӨВЧТӨНД ТЭМДЭГЛЭНЭ.

### 3. СҮРЬЕЭТЭЙ ӨВЧТӨНГ БҮРТГЭХ

#### Сүрьеэтэй өвчтөний бүртгэл (ТВ-03)

Сүрьеэтэй болох нь тогтоогдсон өвчтөнийг сум өрхийн эмч сүрьеэгийн диспансерт илгээж оношлогдсон өвчтөн бүрийг “Сүрьеэтэй өвчтөний бүртгэл” ТВ-03 журналд бүртгэсний дараа эмчилгээнд оруулна. Бүртгэлийг бүрэн хийхгүйгээр сүрьеэтэй өвчтөний тоо ялангуяа шинэ болон давтан эмчилгээнд орж буй өвчтөний тоо, халдваргүй болсон хувь, эдгэрэлтийн түвшинг тогтоож сар улирлын тайлан гаргах боломжгүй юм.

Сүрьеэтэй өвчтөний бүртгэлд дараах мэдээллүүд байна.

Бүртгэгдсэн он сар өдөр: Тухайн өвчтөн диспансерийн хяналтанд орсон өдрийг тодорхойлох бөгөөд ТВ-01-д бичигдсэн өдөртэй тохирч байх ёстой.

Бүртгэлийн дугаар: Тайлангийн жилийн эхнээс бүртгэгдсэн өвчтөн бүрийг давтагдахгүй дугаарлах бөгөөд мөн ТВ-01-д бичигдсэн дугаартай таарч байх ёстой.

Эцэг /эх/ийн ба өөрийн нэр, нас, хүйс, гэрийн хаягийг тодорхой бүрэн бичнэ.

Хаана эмчлэгдэх: Энэ хүснэгтийг эрчимт болон үргэлжлэх шатны эмчилгээг хаана хийлгэх гэсэн 2 мөр болгож болох бөгөөд өвчтөнтэй ярилцаж эмчилгээний үргэлжлэх хугацаа, шууд хяналттай эмчилгээний хяналтын талаар зөвлөгөө өгч өвчтөний биеийн байдлыг үнэлэн хаана эмчлэгдэхийг больниц, диспансер, сайн дурын идэвхтэн, хоол эмчилгээний цэг, өрхийн эмнэлгээр гэх мэтчилэн тэмдэглэнэ.

Эмчилгээ эхэлсэн он сар өдөр: Өвчтөн сүрьеэгийн эмчилгээ хийлгэж эхэлсэн хугацааг тодорхой бичих бөгөөд энэ тэмдэглэгээ ТВ-01-тэй тохирч байх ёстой. Эмчилгээ эхэлсэн он сар өдөр ихэвчлэн бүртгэгдсэн он сар өдөртэй давхцадаг боловч клиникийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн тохиолдолд бүртгэлд орохоос өмнө эмчилгээ эхэлсэн байдгийг анхаарна уу.

Өвчний ангилал: Тухайн хүснэгтэнд сүрьеэ өвчний байршлийг уушгины, уушгины бус эрхтэний (У, УБЭ) гэж, эмчилгээний бүлгийг У-I, УБЭ-III, У-II гэх мэт тодорхой бичнэ.

Бүртгэгдсэн байдал: Өмнө нь сүрьеэгийн эмчилгээ хийлгэж байсан эсэхээс шалтгаалан:

- Шинэ
- Дахилт
- Шилжиж ирсэн
- Тасалсны дараа
- Үр дүнгүй
- Бусад гэсэн ангилалуудаас сонгон тэмдэглэнэ.

Цэрний ба бусад шинжилгээний хариу: Эмчилгээний өмнө хийгдсэн цэрний түрхэцийн шинжилгээний хариу ба ХДХВ-ын шинжилгээний хариу, хяналтын 2,3,5,6 /8/ дахь саруудын хариуг он сар өдөр, лабораторийн дугаартай нь тэмдэглэнэ.

Эмчилгээний үр дүн:

- Эдгэрсэн
- Эмчилгээ дуусгасан
- Нас барсан
- Эмчилгээ үр дүнгүй
- Эмчилгээ тасалсан
- Шилжсэн гэсэн үзүүлэлтээс аль тохирохыг сонгон, эмчилгээ дуусгасан он сар өдрийг тэмдэглэнэ.

Нэг хуудсанд 10 өвчтөний мэдээлэл багтах бөгөөд хуудас бүрийн төгсгөлд тухайн хуудсанд бүртгэгдсэн өвчтөнийг бүртгэгдсэн ангилалын дагуу дүгнэж тэмдэглэх нь тайлан мэдээ гаргахад хялбар болох юм.

## Сүрьеэтэй өвчтөний бүртгэл

| Бүртгэгдсэн сар өдөр | дугаар | Эцэг /эх/ийн ба өөрийн нэр | Нас | Хүйс | Гэрийн хаяг               | Хаана амчлалдаг | Эмчлгээ эхэлсэн сар өдөр | Өвчний ангилал, эмчилгээний шинэглэл | Бүртгэгдсэн байдал |        |              |                |           |       |
|----------------------|--------|----------------------------|-----|------|---------------------------|-----------------|--------------------------|--------------------------------------|--------------------|--------|--------------|----------------|-----------|-------|
|                      |        |                            |     |      |                           |                 |                          |                                      | Шинэ               | дахилт | Шилжиж ирсэн | Тасалсны дараа | Үр дүнгүй | бусад |
| IV-6                 | 197    | Туул Өсөхбаяр              | 28  | эм   | СХД-23 хороо Хангай 44-24 | өрх             | III-5                    | У1                                   | +                  |        |              |                |           |       |
| IV-7                 | 198    | Лхагвасүрэн Энхжин         | 2   | эм   | СХД-1 хороо Т-98-530      | дис             | IV-7                     | УIII                                 | +                  |        |              |                |           |       |
| IV-7                 | 199    | Баттөмөр Баттулга          | 17  | эр   | СХД-10 хороо ЗБУ-16-47    | дис             | IV-10                    | УБIII                                | +                  |        |              |                |           |       |
| IV-7                 | 200    | Янжмаа Тэгшбат             | 24  | эр   | СХД-7 хороо БХ 12-30      | өрх             | IV-5                     | УБ1                                  | +                  |        |              |                |           |       |
| IV-7                 | 201    | Цэрэндаш Батсайхан         | 46  | эр   | СХД-10 хороо ЗБУ 30-16    | дис             | IV-6                     | У1                                   | +                  |        |              |                |           |       |
| IV-7                 | 202    | Сайнбаяр Түвшинжаргал      | 33  | эр   | СХД-9 хороо ЗС-9-15       | дис             | III-29                   | УII                                  |                    | +      |              |                |           |       |
| IV-13                | 203    | Даваадорж Баярсайхан       | 24  | эр   | СХД-18 хороо 14-15        | дис             | IV-13                    | УII                                  |                    |        |              |                | +         |       |
| IV-14                | 204    | Өнөбат Өнержаргал          | 33  | эм   | СХД-23 хороо Хангай 61-8  | дис             | IV-14                    | У1                                   | +                  |        |              |                |           |       |
| IV-16                | 205    | Баянбат Золбаяр            | 19  | эр   | СХД-2 хороо Орбит-32-560  | дис             | IV-12                    | УII                                  |                    |        |              |                | +         |       |
| IV-19                | 206    | Дэмбэрэл Энхтуяа           | 60  | эм   | СХД-7 хороо МЛ-1-20       | СДИ             | III-20                   | У1                                   |                    |        |              |                | +         |       |
| Шинэ Т/+/-           |        | 3                          |     |      |                           |                 |                          |                                      |                    |        |              |                |           |       |
| Шинэ Т/-             |        | 1                          |     |      |                           |                 |                          |                                      |                    |        |              |                |           |       |
| УБЭ                  |        | 2                          |     |      |                           |                 |                          |                                      |                    |        |              |                |           |       |
| Дахилт               |        | 1                          |     |      |                           |                 |                          |                                      |                    |        |              |                |           |       |
| Тасалсны дараа       |        | 1                          |     |      |                           |                 |                          |                                      |                    |        |              |                |           |       |
| Үр дүнгүй            |        | 1                          |     |      |                           |                 |                          |                                      |                    |        |              |                |           |       |
| Шилжиж ирсэн         |        | 1                          |     |      |                           |                 |                          |                                      |                    |        |              |                |           |       |
| бусад                |        | 0                          |     |      |                           |                 |                          |                                      |                    |        |              |                |           |       |



#### 4. СҮРЬЕЭГИЙН ТОХИОЛДЛЫГ ТОДОРХОЙЛОХ

*Сүрьеэтэй өвчтөний эмчилгээ хяналтын карт (ТВ 01)*

Сүрьеэгийн диспансерийн хяналтанд орж, сүрьеэгийн эмчилгээ хийлгэж байгаа өвчтөн тус бүрд "Сүрьеэтэй өвчтөний эмчилгээ хяналтын карт"-ыг хөтөлнө. / Хавсралт 1/.

Уг карт нь өвчтөний тухай дараах мэдээллүүдийг агуулна.

- Өвчний ангилал
- Бүртгэгдсэн байдал
- Илрүүлэлт
- Халдварын эх уурхай
- Эмчилгээний горим
- Уух эмийн тун, хугацаа
- Эмчилгээний эхэнд ба явцад хийгдсэн цэрний шинжилгээний хариу
- ХДХВ-ийн шинжилгээний байдал
- Эмийг хянаж уулгасан байдал
- Зөвлөгөө өгсөн байдал
- Өвчтөний хавьтал
- Бүртгэлээс хасагдсан байдал

Картын эхний хэсэгт өвчтөний тухай ерөнхий мэдээллүүд багтана. Үүнд:

- Овог, нэр
- Нас
- Хүйс
- Регистрийн дугаар
- Оршин суугаа хаяг
- Ажлын газар, албан тушаал, мэргэжил
- Аймаг, дүүргийн нэр
- Бүртгэлийн дугаар

#### **Сүрьеэтэй өвчтөний эмчилгээ хяналтын карт**

*Эцэг /эх/ийн нэр\_Туул\_\_нэр\_\_Өсөхбаяр\_\_нас\_28\_хүйс\_эм\_*

*Регистрийн дугаар\_ЧТ83072561\_\_*

*Хаяг\_\_СХД 23 хороо Хангай 44-24*

*Ажлын газар, албан тушаал, мэргэжил\_\_\_ажилгүй*

*Аймаг, дүүргийн нэр \_\_СХЭМН\_\_\_\_\_*

*Бүртгэлийн дугаар \_\_ТВ01-197\_\_*

Дараах хэсэгт өвчний тухай мэдээллүүд багтана. Үүнд:

- Өвчний ангилал: уушгины, уушгины бус эрхтэний
- Өвчин эхэлсэн, эмчид анх үзүүлсэн, бүртгэлд авсан он, сар, өдөр
- Бүртгэгдсэн байдал

*Ангилал: уушигны +, УБЭ*

*Өвчин эхэлсэн...2010..он...3..сар..1..өдөр*

*Эмчид анх үзүүлсэн ...2010..он...3..сар..4..өдөр*

*Бүртгэлд авсан ...2010..он...4..сар..6..өдөр*

*Бүртгэгдсэн байдал:*

*шинэ + дахилт шилжиж ирсэн үр дүнгүй бусад эмчилгээ тасалсан*

Сүрьеэ өвчнийг эмгэг өөрчлөлттэй эрхтэн тогтолцоогоор нь уушгины, уушгины бус эрхтэний сүрьеэ гэж ангилна. Уушгины эмнэл зүйн шинжүүд илэрч нян судлалын болон гэрлийн шинжилгээгээр батлагдсан тохиолдлыг уушгины, уушгинаас бусад эрхтэний эмнэл зүй илэрч эд, эсийн эсвэл нян судлалын шинжилгээгээр батлагдсан тохиолдлыг уушгины бус эрхтэний гэж авна.

Сүрьеэтэй өвчтөнг бүртгэлд авахдаа дараах байдлаар тодорхойлно:

- *Шинэ* Сүрьеэгийн эмчилгээ огт хийлгэж байгаагүй эсвэл сүрьеэгийн эмийг нэг сар хүртлэх хугацаагаар хэрэглэсэн тохиолдол
- *Дахилт* Сүрьеэгийн эмчилгээг амжилттай дуусгасан өвчтөн дахин сүрьеэгээр өвчилж түрхэц эерэг болсон тохиолдол
- *Шилжиж ирсэн* Сүрьеэгийн эмчилгээ хийлгэж байх хугацаанд өөр аймаг дүүргээс шилжиж ирсэн тохиолдол
- *Эмчилгээ тасалсны дараах* Сүрьеэгийн эмчилгээг 2 сар ба түүнээс дээш хугацаагаар орхисны дараа түрхэц эерэг болж эмчилгээ дахин эхэлж байгаа тохиолдол
- *Үр дүнгүй* Сүрьеэгийн эмчилгээний хяналтын 5 дахь сард түрхэц эерэг байгаа тохиолдол
- *Бусад:* Дээр дурьдагдсан ангилалд хамруулах боломжгүй тохиолдол

Сүрьеэтэй өвчтөн илрүүлэлтийн ямар аргаар илэрснийг тодорхойлно.

- *Идэвхтэй илрүүлэлт* хүн амын дунд зориудын урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж сүрьеэгийн тохиолдлыг илрүүлэх
- *Идэвхгүй илрүүлэлт* эмчид хандсан үйлчлүүлэгчдийн дундаас сүрьеэгийн сэжигтэй тохиолдлыг сонгон, үзлэг шинжилгээ хийж илрүүлэх
- *Хагас идэвхтэй илрүүлэлт* өвчлөх эрсдэл өндөртэй хүн амын дунд урьдчилан сэргийлэх үзлэг хийж илрүүлэх

Халдварын эх уурхай хэсгийг бөглөхдөө гэр бүлийн болон бусад хүмүүсийн хүрээнд сүрьеэгээр өвчилсөн хүн байсан эсэхийг асууж тодруулна.

|                             |   |                                    |
|-----------------------------|---|------------------------------------|
| <i>Илрүүлэлт</i>            |   | <i>Халдварын эх уурхай</i>         |
| <i>идэвхтэй үзлэг</i>       | + | <i>халдвартай сүрьеэтэй өвчтөн</i> |
| <i>идэвхгүй үзлэг</i>       |   | <i>архаг сүрьеэтэй өвчтөн</i>      |
| <i>хагас идэвхтэй үзлэг</i> |   | <i>тогтоогдоогүй +</i>             |

## 5. СҮРЬЕЭГИЙН ЭМЧИЛГЭЭ

**Эрчимт ба үргэлжлэх эмчилгээний шат** /горим, эмийн тун хэсгийг дараах байдлаар тэмдэглэнэ.

Бүлэг 1-д шинэ түрхэц эерэг уушгины сүрьеэ, шинэ түрхэц сөрөг уушгины талбайг их хэмжээгээр хамарсан өөрчлөлттэй, шинэ уушгины бус эрхтэний сүрьеэгийн хүнд хэлбэрийг хамруулж эмийн тун тус бүрийг тухайн бүлэгт хэрэглэгдэх эмийг заасан тэмдэглэгээний дээд нүдэнд бичнэ.

Бүлэг 2-д дахилт, үр дүнгүй эмчлэгдсэн, эмчилгээ тасалсаны дараах, бусад тохиолдлыг хамруулж эмийн тун тус бүрийг мөн тэмдэглэгээний дээд нүдэнд бичнэ.

Бүлэг 3-д шинэ, түрхэц сөрөг уушгины сүрьеэ, шинэ, уушгины бус эрхтэний (I бүлэгт орсноос бусад) сүрьеэгийн хэлбэрийг хамруулж тэмдэглэгээний аль тохирохыг сонгож эмийн тунг дээд нүдэнд бичнэ.

Шинээр эмчилгээнд орж буй цөөн тохиолдолд хавсарсан өвчний заалтаар 12

сарын эмчилгээнд оруулж зохих горимыг сонгон тунг бичнэ.

Урьдчилан сэргийлэх эмчилгээ хийлгэж байгаа тохиолдолд тохирох горимыг сонгон тунг бичнэ.

*1. Эрчимт эмчилгээний шат /горим, эмийн тунг/*

| Бүлэг 1 +<br>Шинэ/Т+, Т- ба<br>шинэ<br>УБЭ-ий сүрьеэгийн<br>хүнд хэлбэр/<br>2HREZ | Бүлэг 2<br>Давтан<br>эмчилгээ<br>3HREZ2S | Бүлэг 3<br>Шинэ Т-, Шинэ<br>УБЭ-ий сүрьеэ<br>2HRZ | 12 сарын<br>2HES | у/с эмчилгээ<br>6H |
|---|--|---|------------------|--------------------|
|---|--|---|------------------|--------------------|

*H-изониазид R-рифампицин E-этамбутол  
Z-пиразинамид S-стрептомицин*

Сүрьеэгийн онош батлагдаж бүртгэлд орсон өдрөөс эхлэн эмийг хяналттай уулгаж эмийн тэмдэглэгээг хийнэ. Эмийн тунг өдөр бүр харж уулган "х" үсгээр тэмдэглэнэ. Сайн дурын идэвхтэн, өрхийн эмнэлгийн хяналтанд өвчтөн эмээ уусан тэмдэглэгээг "с", "ө" үсгээр, эмчилгээ тасалсан өдрүүдийг "т" үсгээр тус тус тэмдэглэнэ. Өвчтөн сүрьеэгийн клиникийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн бол ТВ-13 маягтыг үндэслэн эм уусан өдрийг "к" үсгээр тэмдэглэж өвчтөн эмийг хяналтгүй өгч явуулсан хоногийг зураасаар тэмдэглэнэ.

*Эм уулгасны дараа сар, өдрийг тэмдэглэнэ.*

| Сар өдөр | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 |   |
|----------|---|---|---|---|---|---|---|---|---|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|---|
| 3        |   |   |   |   | к | к | к | к | к | к  | к  | к  | к  | к  | к  | к  | к  | к  | к  | к  | к  | х |
| 4        | х | х | б | б | х | х | х | х | х | б  | б  | Т  | Т  | х  | х  | х  | б  | б  | х  | х  | Т  | Т |
| 5        | б | б | х | Т | Т | Т | Т | Т | Т | х  | х  | х  | х  | х  | б  | б  | х  | х  | х  | х  | х  | х |
| 6        | х | х | х | х | б | б | х |   |   |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |   |

Уушгины сүрьеэгийн сэжигтэй хүнд цэрний түрхэцийн шинжилгээ хийж хариуг "Цэрний шинжилгээний хуудас" ТВ-05 маягтыг үндэслэн бичнэ. Хяналтын сарын шинжилгээг тухай бүрд хийж тэмдэглэн, шаардлагатай тохиолдолд өсгөвөрлөх, эмийн дасал тодорхойлох болон рентген шинжилгээ хийж өвчтөний жинг үзэн хариуг тэмдэглэнэ.

*Нян илрэлтийн байдал ба эмэнд мэдрэг байдал*

| Цэрний шинжилгээ |             |        |       |              |         |   |   | рентген | жин |
|------------------|-------------|--------|-------|--------------|---------|---|---|---------|-----|
| сар              | Орон нутагт |        |       | Лавлах лаб.д |         |   |   |         |     |
|                  | өдөр        | Энгийн | Лаб № | Энгийн       | Өсгөвөр | М | Д |         |     |
| 0                | 5/III       | 2+     | 435   |              |         |   |   | нэвчдэс | 56  |
| 2                | 7/IV        | 2+     | 966   |              |         |   |   |         |     |

|      |         |     |      |  |  |  |  |  |      |
|------|---------|-----|------|--|--|--|--|--|------|
| 3    | 11/VI   | Сөр | 1235 |  |  |  |  |  |      |
| 5    | 16/VIII | Сөр | 2013 |  |  |  |  |  | 57.5 |
| 6/8/ | 27/IX   | Сөр | 2095 |  |  |  |  |  |      |
| 12   |         |     |      |  |  |  |  |  |      |

Сүрьеэтэй өвчтөнд удаан хугацааны эмчилгээ шаардагддаг тул эмчилгээний явц, үргэлжлэх хугацаа, хяналтын шинжилгээ, гаж нөлөөний талаар мэдээлэл өгч зөвлөгөө өгөн тэмдэглэж өвчтөнөөр гарын үсэг зуруулна.

Зөвлөгөө өгсөн байдал:

1. ..2010.. сар ...4-6.. өдөр үйлчлүүлэгчийн гарын үсэг .....Өсөхөө.....
2. ..2010...сар ..5-7....өдөр үйлчлүүлэгчийн гарын үсэг .....Өсөхөө.....
3. ..2010...сар ...8-16...өдөр үйлчлүүлэгчийн гарын үсэг .....Өсөхөө.....
4. ....сар .....өдөр үйлчлүүлэгчийн гарын үсэг .....
5. ....сар .....өдөр үйлчлүүлэгчийн гарын үсэг .....

Сүрьеэтэй бүртгэгдсэн тохиолдолд үйлчилгээ үзүүлэгчийн санаачилгаар ХДХВ илрүүлэх шинжилгээ хийж он сар, өдөр, хариуг тэмдэглэнэ.

2010 он....3....сар....5....өдөр  
Хариу.....сөрөг.....

Клиникийн онош, хүндрэл, дагалдах өвчнийг бичиж тэмдэглэн дараагийн хуудсанд шилжинэ.

Клиникийн онош: *Ds: Инфилтративный туберкулез правого легкого с образованным каверным в фазе распада ХТН I+/*

Хүндрэл:

Дагалдах өвчнүүд: *gr 23-24*

Сүрьеэтэй өвчтөний хяналтын картны арын хуудсанд өвчтөний үргэлжлэх шатны эмчилгээ хийлгэж буй горимыг тэмдэглэх бөгөөд хяналттай уусан эсэхийг өмнөх зааврын дагуу өдөр бүр хөтөлнө.

2. Үргэлжлэх эмчилгээний шат

|   |                               |                          |                     |                      |
|---|-------------------------------|--------------------------|---------------------|----------------------|
| Бүлэг 1 +<br>Шинэ/Т+, Т- ба<br>шинэ                     | Бүлэг 2<br>Давтан<br>эмчилгээ | Бүлэг 3<br>УБЭ-ий сүрьеэ | 12 сарын<br>Шинэ Т- | у/с эмчилгээ<br>Шинэ |
| УБЭ-ий сүрьеэгийн<br>хүнд хэлбэр/<br>4HR<br>H2R2<br>6HE |                               |                          |                     |                      |
| 5HRE<br>5H2R2E2   |                               | 4HR<br>4H2R2<br>6HE      | 10HE                |                      |

|          |   |   |   |   |   |   |   |   |   |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |   |
|----------|---|---|---|---|---|---|---|---|---|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|---|
| Сар өдөр | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 |   |
| 6        |   |   |   |   |   |   |   | Т | Т | Т  | Х  | Б  | Б  | Х  | Х  | Х  | Х  | Х  | Б  | Б  | Х  | -  |   |
| 7        | ө | ө | Б | Б | ө | ө | ө | ө | ө | б  | б  | ө  | ө  | ө  | ө  | ө  | б  | б  | ө  | ө  | ө  | б  |   |
| 8        | б | ө | ө | ө | ө | ө | б | б | ө | ө  | ө  | ө  | ө  | б  | б  | ө  | ө  | ө  | ө  | ө  | ө  | б  | ө |
| 9        | ө | ө | ө | б | б | ө | ө | ө | ө | ө  | б  | б  | ө  | ө  | ө  | ө  | ө  | б  | б  | ө  | ө  |    |   |



Амьсгалын замаар дамжин халдварладаг сүрьеэ өвчин гэр бүлийн гишүүдийг халдварлуулах магадлал өндөр байдаг тул ойрын хавьтлыг бүртгэн үзлэг шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулж үр дүнг тэмдэглэнэ.

**Өвчтний хавьтал:**

| № | Овог нэр   | Нас | Хүйс | Хэн болох | сорил  |      | Цэрний шинжилгээ |       | Рентген шинжилгээ |       |
|---|------------|-----|------|-----------|--------|------|------------------|-------|-------------------|-------|
|   |            |     |      |           | хийсэн | үгүй | Сар өдөр         | хариу | Сар өдөр          | Хариу |
| 1 | Нямдаваа   | 33  | эр   | Нөхөр     |        |      |                  |       | 15/IV             | Эрүүл |
| 2 | Алтан-Очир | 9   | эр   | Хүү       | 10мм   |      |                  |       | 15/IV             | Эрүүл |
| 3 | Аззаяа     | 4   | эм   | охин      | 7мм    |      |                  |       |                   |       |
|   |            |     |      |           |        |      |                  |       |                   |       |

Сүрьеэ гэж оношлогдон бүртгэлд орж эмчилгээ хийлгэсэн өвчтөний эмчилгээний үр дүн 6-12 сарын дараа гарах бөгөөд бүртгэлээс хасагдах болсон шалтгааныг дараах тодорхойлолтын аль тохирохыг зурж, хасагдсан он сар өдрийг тэмдэглэнэ.

**Эдгэрсэн:** Уушгины түрхэц эерэг сүрьеэтэй өвчтөн эмчилгээний хяналтын сүүлийн 2 ба түүнээс дээш удаагийн түрхэцийн шинжилгээнд дараалан “сөрөг” болсон тохиолдол

**Эмчилгээ дуусгасан:** Уушгины түрхэц эерэг сүрьеэтэй өвчтөн эмчилгээний хяналтын шинжилгээг бүрэн хийлгээгүй, эсвэл уушгины түрхэц сөрөг сүрьеэтэй болон уушгины бус эрхтэний сүрьеэтэй өвчтөн эмчилгээг бүрэн хийлгэсэн тохиолдол

**Үр дүнгүй:** Уушгины түрхэц эерэг сүрьеэтэй өвчтөн эмчилгээний 5 дахь болон түүнээс хойшхи сард, уушгины түрхэц сөрөг сүрьеэтэй өвчтөн эмчилгээний 2 дахь сард түрхэц эерэг болсон тохиолдол

**Тасалсан:** Эмчилгээний хугацаанд дараалан 2 сар, түүнээс дээш хугацаагаар эмчилгээ тасалсан тохиолдол

**Шилжсэн:** Эмчилгээний явцад өөр аймаг дүүрэгт шилжсэн тохиолдол

**Нас барсан:** Эмчилгээ хийлгэж байх хугацаанд ямар нэг шалтгаанаар нас барсан тохиолдол

**Амжилттай эмчлэгдсэн:** Эдгэрсэн болон эмчилгээ дуусгасан уушгины түрхэц эерэг тохиолдолын нийлбэр

Сүрьеэтэй өвчтөний эмчилгээ хяналтын картыг эмч, сувилагч хөтөлнө. Хэрэв өвчтөн шилжиж ирсэн бол “Өвчтөнг шилжүүлсэн мэдээ” ТВ 09-г үндэслэн ТВ 01-ийг шинээр хөтөлнө.

**Бүртгэлээс хасагдсан:**

..2010..он.....11.....сар.....02 өдөр

**Шалтгаан:** эдгэрсэн, эмчилгээ дууссан, нас барсан, эмчилгээ тасалсан, үр дүнгүй, шилжсэн /зур/

Нас барсан: .....он.....сар.....өдөр /сүрьеэгээр, өөр өвчнөөр/

## 6. СҮРЬЕЭТЭЙ ӨВЧТӨНГ БҮРТГЭГДСЭН ЭСЭХИЙГ ШАЛГАХ

Аймаг, дүүргийн сүрьеэгийн зохицуулагч эмч нь халдвартай сүрьеэтэй гэж оношлогдсон өвчтөн бүр бүртгэлд орсон эсэхийг 14 хоног тутамд шалгана. Эмч “Лабораторийн шинжилгээний бүртгэл” (ТВ 04)-ийг үзэж түрхэц эерэг өвчтөн бүр “Сүрьеэтэй өвчтөний бүртгэл (ТВ 03)-д бүртгэгдсэн эсэхийг өвчтөний овог нэрээр нь тулгалт хийж шалгана. Сүүлийн удаа лабораторт очсоноос хойш бүртгэгдсэн Т /+/ шинэ болон дахилттай өвчтөний овог нэр шинжилгээний дугаар “лабораторийн шинжилгээний бүртгэл” ТВ 04-т бичигдсэнтэй тохирч байгаа эсэхийг шалгана.

Т /+/ бүх өвчтөнг “шинжилгээний зорилго” (оношлогоо, эмчилгээний хяналт) багананд тэмдэглэсэн эсэхийг үзнэ.

Т /+/ бүх өвчтөн “шинжилгээний хариу” багананд (1+, 2+, 3+) тэмдэглэгдсэнийг шалгана.

Лабораторын шинжилгээний дугаарын дэргэд харандаагаар тулгалт хийсэн тэмдэг тавина. Тэмдэггүй үлдсэн нь бүртгэгдээгүй, шинэ болон дахилттай түрхэц эерэг өвчтөн болно.

Бүртгэгдээгүй өвчтөний овог, нэр, нас, хаяг, лабораторийн шинжилгээний дугаар, цэрний шинжилгээ хийсэн он, сар, өдөр, шинжилгээний хариуг бичиж аван, бүртгэгдээгүй өвчтөнийг хяналтанд оруулах арга хэмжээг яаралтай авна. Дараа нь шалгалт хийж дууссан шугам дээр тэмдэг тавьж дараагийн тулгалтыг уг тэмдгээс эхэлнэ.

## 7. СҮРЬЕЭТЭЙ ӨВЧТӨНИЙ МЭДЭЭЛЭЛ

### Сарын тайлан гаргах

*Шинэ болон давтан бүртгэгдсэн өвчтөний сарын тайлан (ТВ 07)*

Шинэ болон давтан бүртгэгдсэн өвчтөний тайлан гаргах нь сүрьеэ өвчний талаархи мэдээллийн нэг чухал хэсэг бөгөөд сүрьеэгийн өвчлөл, илрүүлэлтийг тооцоолоход чухал ач холбогдолтой.

Онош батлагдаж бүртгэлд орсон өвчтөний сарын тайланг ТВ-03 маягтыг үндэслэн, сүрьеэгийн дүн бүртгэл хариуцсан бага эмч /сувилагч/ тухайн сарын сүүлчийн өдрөөр тасалбар болгон гаргаж, сүрьеэгийн зохицуулагч эмчээр хянуулан дараа сарын 10-ны дотор сүрьеэгийн тандалт судалгааны албанд явуулна.

Сүрьеэгийн тандалт судалгааны алба нь тайланг нэгтгэн дүн шинжилгээ хийж, аймаг дүүргүүдийг харьцуулж улсын үзүүлэлтүүдийг гарган улирал, хагас жил бүр сүрьеэгийн диспансеруудад эргэн мэдээлнэ. Ингэснээр сүрьеэтэй тэмцэх ажлыг илүү оновчтой төлөвлөж үр дүнд хүрэхэд ач холбогдолтой болно.

Шинэ болон давтан бүртгэгдсэн өвчтөний сарын тайлан ТВ-07 маягт нь 4 хүснэгтээс бүрдэх бөгөөд 1-р хүснэгтэнд шинэ болон давтан эмчилгээтэй өвчтөнийг уушгины түрхэц эерэг шинэ /1/, давтан эмчилгээнд орсон /2/, дахилт /2а/, үр дүнгүй /2б/, эмчилгээ тасалсан /2в/, уушгины түрхэц сөрөг /3/, уушгины бус эрхтэний /4/, бусад /5/ уушгины /5а/, уушгины бус эрхтэний /5б/, бүгд /6/ баганы дагуу хүйсээр нь ялган нийлбэрийг гаргана.

*Шинэ болон давтан бүртгэгдсэн өвчтөний*

*..2010...оны....4... сарын тайлан*

*Аймаг, дүүрэг....Сонгинохайрхан дүүрэг*

## 1. Шинэ болон давтан эмчилгээтэй өвчтөний бүртгэл

| Уушгины түрхэц эерэг |    |                             |    |                |    |                        |    | Уушгины түрхэц сөрөг /3/ | Уушгины бус эрхтний /4/ | бусад /5/    |    |          |    |    |    | Бүгд /6/ |    |      |
|----------------------|----|-----------------------------|----|----------------|----|------------------------|----|--------------------------|-------------------------|--------------|----|----------|----|----|----|----------|----|------|
| Шинэ /1/             |    | давтан эмчилгээнд орсон /2/ |    |                |    |                        |    |                          |                         | уушгины /5a/ |    | УБЭ /5б/ |    |    |    |          |    |      |
|                      |    | дахилт /2a/                 |    | үр дүнгүй /2б/ |    | эмчилгээ тасалсан /2в/ |    |                          |                         |              |    |          |    |    |    |          |    |      |
| эр                   | эм | эр                          | эм | эр             | эм | эр                     | эм | эр                       | эм                      | эр           | эм | эр       | эм | эр | эм | эр       | эм | бүгд |
| 1                    | 2  | 1                           | -  | 1              | -  | 1                      | -  | -                        | 1                       | 2            | -  | -        | -  | -  | -  | 6        | 3  | 9    |

Шилжиж ирсэн 1 өвчтөнийг хүснэгтийн доод хэсэгт мэдээлнэ.

Д.Энхтуяа 2010 оны IV сарын 19-нд Архангай аймгаас шилжиж ирсэн. Уушгины түрхэц сөрөг I бүлэг.

2-р хүснэгтэнд шинэ илэрсэн өвчтөний насны ангилал /1+3+4/-ыг хэлбэр тус бүрээр нь хүйсээр ялган тэмдэглэнэ.

## 2. Шинэ илэрсэн өвчтний насны ангилал /1+3+4/

|              | 0-1 |    | 2-7 |    | 8-14 |    | 15 |    | 16-24 |    | 25-34 |    | 35-44 |    | 45-54 |    | 55-64 |    | 65< |    | Бүгд |    |      |
|--------------|-----|----|-----|----|------|----|----|----|-------|----|-------|----|-------|----|-------|----|-------|----|-----|----|------|----|------|
|              | эр  | эм | эр  | эм | эр   | эм | эр | эм | эр    | эм | эр    | эм | эр    | эм | эр    | эм | эр    | эм | эр  | эм | эр   | эм | бүгд |
| Түрхэц эерэг |     |    |     |    |      |    |    |    |       |    | 2     |    |       |    | 1     |    |       |    |     |    | 1    | 2  | 3    |
| Түрхэц сөрөг |     |    |     | 1  |      |    |    |    |       |    |       |    |       |    |       |    |       |    |     |    | -    | 1  | 1    |
| УБЭ          |     |    |     |    |      |    |    |    | 2     |    |       |    |       |    |       |    |       |    |     |    | 2    | -  | 2    |
| Бүгд         |     |    |     | 1  |      |    |    |    | 2     |    | 2     |    |       | 1  |       |    |       |    |     |    | 3    | 3  | 6    |

3-р хүснэгтэнд лабораторийн үйл ажиллагааг гаргахдаа лабораторийн ТВ-04 журналын оношлогооны зорилгоор түрхэцийн шинжилгээ хийлгэсэн сүрьеэгийн ысэжигтэй хүний тоо, үүнээс түрхэц эерэг гарсан сүрьеэгийн тохиолдлын тоог гаргана.

## 3. Лабораторийн үйл ажиллагаа

| Түрхэцийн шинжилгээ өгсөн сүрьеэгийн сэжигтэй хүний тоо | Түрхэц эерэг гарсан сүрьеэгийн тохиолдлын тоо |
|---|---|
| 38  | 6   |

4-р хүснэгтэнд Сүрьеэ, ХДХВ-ийн шинжилгээний мэдээлэл байх бөгөөд бүртгэгдсэн бүх тохиолдол ба шинэ тохиолдлоос ХДХВ-ын шинжилгээ хийлгэсэн өвчтний тоо, үүнээс эерэг гарсан өвчтний тоог тэмдэглэнэ. Өмнөх сард бүртгэлд орж ХДХВ-ийн шинжилгээ өгөгдөөгүй байсан өвчтөний хариуг нэмэн тэмдэглэж болно.

## 4. Сүрьеэ, ХДХВ

|                                     | Эмчилгээний өмнө ба эмчилгээний явцад ХДХВ-ийн шинжилгээ хийлгэсэн өвчтний тоо | Үүнээс эерэг гарсан өвчтний тоо |
|-------------------------------------|--|---------------------------------|
| Бүртгэгдсэн бүх шинэ тохиолдлын тоо | 5  | 0                               |
| Бүртгэгдсэн бүх тохиолдол           | 8  | 0                               |

## САРЫН ТАЙЛАНД ДҮГНЭЛТ ХИЙХ

ХӨСҮТ-ийн сүрьеэгийн тандалт судалгааны албанаас улирал, хагас, бүтэн жилээр гаргадаг улсын тайлан болон өнгөрсөн жилийн өөрийн аймаг, дүүргийн тайланг харьцуулж дүгнэлт хийнэ. Доорх хүснэгтээс тайлангийн үзүүлэлтүүдэд тайлбар авч цаашид авах арга хэмжээг төлөвлөнө.

| Үзүүлэлт  | Шалтгаан  | Авах арга хэмжээ  |
|---|---|---|
| Шинээр илэрсэн Т /+/ өвчтний тоо бага бол                     | Нутаг дэвсгэрийн хүн амын дундах сүрьеэгийн сэжигтэй хүмүүсийг илрүүлж чадахгүй байна. Сүрьеэгийн сэжигтэй тохиолдол, үнэ төлбөргүй оношлогоо эмчилгээ хийлгэх талаар мэдээлэл сургалт сурталчилгаа хангалтгүй байна. | Өөрийн аймаг дүүргийн сүрьеэтэй өвчтөний оношийн баталгаажилтийг гаргана. Хэрэв 70%-аас доош байвал сүрьеэтэй өвчтөнийг илрүүлэхэд өрх, сумын эмч нарын оролцоог дээшлүүлэх<br>Харьяа төрийн болон төрийн бус байгууллагуудыг нийгмийн халдварт өвчинтэй тэмцэх ажилд оролцуулах бодлого төлөвлөгөө гарган ажиллах. |
|   | Цэрний шинжилгээний чанар сайн биш  | Цэрийг зөв авахаас эхлэн шинжилгээний хариу гарах хүртэл бүх шатны ажлыг сайжруулах   |
| Түрхэц сөрөг тохиолдол хэт олон                               | Цэрийг зөв цуглуулж чадахгүй байна.   |   |
| Дахилттай өвчтний тоо их                                      | Архаг өвчтнийг дахилт гэж авсан.  | Эмчилгээ эхлэхээс өмнө төвлөрсөн бүртгэлээс хянуулж үзэх  |
| Эмчилгээ тасалсан болон үр дүнгүй эмчлэгдсэн өвчтний тоо олон | Шууд хяналттай эмчлэх зарчим баримтлахгүй байна. Эмчилгээний горимыг буруу сонгосон. Эмэнд дасалтай сүрьеэ үүсэх аюултай.   | Үргэлжлэх шатны эмчилгээг өвчтөнд ойртуулах зорилгоор өрх, сумын эмчийн хяналтанд эмчлэх<br>Өвчтөнд эмчилгээ таслахын хор холбогдлыг тайлбарлан хэлэх   |
| Уушгины бус эрхтний сүрьеэгийн тоо хэт их                     | Оношлогоо буруу<br>ХДХВ-ын тархалт өндөр  | Холбогдох шинжилгээг сайн хийх, эмч нарын зөвлөгөөнөөр эмчилгээний асуудлыг шийдвэрлэх<br>Өвөрмөц бус антибиотик эмчилгээ эхэлж хийх  |
| Уушгины болон уушгины бус эрхтний бусад сүрьеэгийн тоо их     | Эмчилгээ хяналтгүй хийгдэх<br>2 түүнээс дээш удаа эмчилгээнд авах<br>Архаг өвчтнийг эмчилгээнд авах   | Эмчилгээ эхлэхээс өмнө төвлөрсөн бүртгэлээс шүүх<br>Шууд хяналттай эмчилгээний зарчмыг мөрдөх   |

### Шинэ илэрсэн өвчтөнийг мэдээлэх

Шинэ илэрсэн өвчтөний нас хүйс, гэр, ажлын газрын хаяг, үндсэн онош, илрүүлэлтийн байдал, өвчлөлийн байдал, халдварын эх уурхай, хавьтлын үзлэгийн мэдээлэл бүхий “Шинээр илэрсэн сүрьеэ өвчнийг мэдээлэх хуудас”-ыг тайлангийн хугацаанд бүртгэлд орсон шинэ тохиолдол бүрд хөтлөн сарын тайлан ТВ-07 маягтын хамт илгээнэ.

### Уушигны түрхэй эерэг өвчтөний эмчилгээний 2(3) дахь сард түрхэц сөрөгт шилжсэнийг дүгнэх

*Уушгины түрхэц эерэг өвчтөний эмчилгээний 2,3 дахь сард түрхэц сөрөгт шилжсэн байдал (ТВ 14)*

Цэрний түрхэцийн шинжилгээ сөрөгт шилжих түвшин нь эрчимт шатны эмчилгээний үр дүн болон өвчтөн эмчийн зааврыг хэрхэн биелүүлж байгаа байдлыг харуулдаг үзүүлэлт юм. Сөрөгт шилжих түвшин гэдэг нь шинээр илэрсэн түрхэц эерэг уушгины сүрьеэгийн тохиолдлоос эрчимт эмчилгээний шат дуусахад түрхэц нь сөрөг болсон

хувь юм. Эмийн дасалгүй, түрхэц эерэг шинэ тохиолдлын 95% нь эрчимт шатны эмчилгээний дараа сөрөгт шилждэг.

Тайлангийн дээд хэсэгт диспансерийн нэр, ямар оны аль улиралд бүртгэгдсэн өвчтөнийг мэдээлэх гэж байгаа болон тайлан гаргасан он, сар, өдөр, тайланг нэгтгэн гаргасан хүний гарын үсэг байна.

Уушгины түрхэц эерэг шинэ тохиолдлын Т /+/-ийн зэрэг, хүйсээр нь ангилж бүртгэгдэж эмчилгээнд орсноос хойш 1 улирлын дараа “Сүрьеэтэй өвчтөний бүртгэл” ТВ-03 журналд тэмдэглэгдсэн шинжилгээний хариуг үндэслэн “Уушгины түрхэц эерэг өвчтөний эмчилгээний 2,3 дахь сард түрхэц сөрөгт шилжсэн байдал” тайланг ТВ-14 маягтаар гаргаж мэдээлнэ.

Дахилт, үр дүнгүй, эмчилгээ тасалсаны дараах тохиолдлын сөрөгт шилжсэн байдлыг мөн гаргана.

Зарим өвчтөн (маш цөөхөн) 2 дахь сардаа сөрөгт шилждэггүй учир эрчимт шатны эмчилгээг 1 сар сунгаад 3 дахь сарын эцэст хийсэн шинжилгээний үр дүнг тооцно.

Эрчимт шатны эмчилгээний төгсгөлд хийгдсэн цэрний түрхэцийн шинжилгээ сөрөг бололгүй эерэг хэвээр байгаа өвчтөн болон эрчимт эмчилгээний шатанд нас барсан, эмчилгээ тасалсан, өөр газар шилжсэн өвчтөний тухай мэдээлэл энд багтана.

*Уушгины түрхэц эерэг өвчтний эмчилгээний  
2,3 дахь сард түрхэц сөрөгт шилжсэн байдал\* ТВ14*

*Диспансерийн нэр \_\_\_\_\_ Сонгинохайрхан дүүргийн сүрьеэгийн диспансер \_\_\_\_\_  
Тайлан гаргасан \_\_\_\_\_ 2010 он 09 сар 30 өдөр  
\_\_\_\_\_ 2010 он II улиралд бүртгэгдсэн өвчтөн  
Гарын үсэг \_\_\_\_\_ Золжаргал \_\_\_\_\_*

| Тайлангийн хугацаанд бүртгэгдсэн өвчтний тоо |    |      |   | Эмчилгээний үр дүн |    |                  |    |            |    |           |    |          |    |         |    |             |    |             |    | Бүгд |
|                  |                     |                      | АЛАТ                   | АСАТ     | Креатинин | Кали      |                                  |                   |                |               | ТСГ                      |
| 0                | 4511                | 4511                 | 17,9                   | 21,4     | 0,5       | 6,4       | T3 -3,56, T4 – 15,26, TSH – 1,16 | OD-08, OS-09      | хэвийн         | 68            | Баруун уушигнд хөндийтэй |
|                  | зэрэг               | зэрэг                | 2008 / 08/11           | 08/08/11 | 08/08/11  | 08/ 08/11 | 08/08/11                         | /08/11            | /08/11         | 08/08/18      | 08/08/10                 |
| 1                |                     |                      | / /                    | / /      | / /       | / /       | / /                              | / /               | / /            | / /           | / /                      |
| 2                |                     |                      | / /                    | / /      | / /       | / /       | / /                              | / /               | / /            | / /           | / /                      |
| 3                |                     |                      | / /                    | / /      | / /       | / /       | / /                              | / /               | / /            | / /           | / /                      |
| 4                |                     |                      | / /                    | / /      | / /       | / /       | / /                              | / /               | / /            | / /           | / /                      |
| 5                |                     |                      | / /                    | / /      | / /       | / /       | / /                              | / /               | / /            | / /           | / /                      |
| 6                |                     |                      | / /                    | / /      | / /       | / /       | / /                              | / /               | / /            | / /           | / /                      |
| 7                |                     |                      | / /                    | / /      | / /       | / /       | / /                              | / /               | / /            | / /           | / /                      |
| 8                |                     |                      | / /                    | / /      | / /       | / /       | / /                              | / /               | / /            | / /           | / /                      |
| 9                |                     |                      | / /                    | / /      | / /       | / /       | / /                              | / /               | / /            | / /           | / /                      |
| 10               |                     |                      | / /                    | / /      | / /       | / /       | / /                              | / /               | / /            | / /           | / /                      |
| 11               |                     |                      | / /                    | / /      | / /       | / /       | / /                              | / /               | / /            | / /           | / /                      |
| 12               |                     |                      | / /                    | / /      | / /       | / /       | / /                              | / /               | / /            | / /           | / /                      |
| 13               |                     |                      | / /                    | / /      | / /       | / /       | / /                              | / /               | / /            | / /           | / /                      |

### Хяналтын шинжилгээ

Хяналтын шинжилгээ хийх зааварчлагын дагуу хийгдсэн шинжилгээний хариуг дээрх байдлаар "ОЭДС-тэй өвчтөний эмчилгээ, хяналтын карт ОЭДС-01" –д тэмдэглэх ба цэрний түрхэцийн ба өсгөврийн шинжилгээний хариу нь "ОЭДС-тэй өвчтөнийг бүртгэх маягт ОЭДС-03" – ын 3, 4 дэх нүүр дээр мөн бичигдэнэ.

"ОЭДС-тэй өвчтөний эмчилгээ, хяналтын карт ОЭДС-01"-ын хяналтын шинжилгээ бичих 4,5 –р нүүрийн баруун доод хэсэгт байгаа "Цэрний түрхэцийн, өсгөврийн шинжилгээний болон эмийн даслын шинжилгээ"-ний хариуг тэмдэглэх зааварчлагыг баримтална.

"ОЭДС-тэй өвчтөний эмчилгээ, хяналтын карт ОЭДС-01"-ын бдахь нүүрэнд эмчилгээний явцад хийгдэж буй хордлого тайлах, элэг хамгаалах, биеийн дархлаа дэмжих зэрэг нэмэлт эмчилгээний мэдээллийг доорхи байдлаар бичнэ.

| д/д | Эмчилгээний сарууд | 0 сар       | 1 сар       | 2 сар       | 3 сар       | 4 сар       | 5 сар       | 6 сар       |
|-----|--------------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|
|     | Эмийн нэр          | Тун, хэмжээ | Тун, хэмжээ | Тун, хэмжээ | Тун, хэмжээ | Тун, хэмжээ | Тун, хэмжээ | Тун, хэмжээ |
| 1   | 0,9% NaCl 250 ml   | 2           |             |             |             |             |             |             |
| 2   | Aloe 1.0 amp       | 30          |             |             |             |             |             |             |
| 3   | Bit A, E мае       | 30          |             |             |             |             |             |             |
| 4   | Карсил мае         | 60          |             |             |             |             |             |             |
| 5   | Зүү, тариур ш      | 30          |             |             |             |             |             |             |
| 6   | Систем ш           | 2           |             |             |             |             |             |             |
| 7   | Салимон фл         | 3           |             |             |             |             |             |             |

### Эмийн гаж нөлөөг хянах

Гарч болох гаж нөлөөг хөнгөн ба хүнд гэж ангилах ба хөнгөн хэлбэрийн гаж нөлөө гарсан үед ихэвчлэн нэмэлт эмчилгээ хийдэг бол хүнд хэлбэрийн гаж нөлөөний үед шинж тэмдгийн эмчилгээ хийх, сүрьеэгийн эсрэг эмчилгээний горим өөрчлөх зэрэг арга хэмжээг авдаг.

"ОЭДС-тэй өвчтөний эмчилгээ, хяналтын карт ОЭДС-01"- ийн 6 дахь хуудсанд байх "нэмэлт /дэмжих/ эмчилгээ гэсэн хүснэгтэнд хөнгөн хэлбэрийн гаж нөлөө гарсан үед хэрэглэсэн эмчилгээний тухай, 7 дахь хуудсанд байх "Гаж нөлөөний хяналт" хүснэгтэнд гарсан гаж нөлөө, түүнтэй холбогдуулан авсан арга хэмжээг тус тус бичнэ.

### ГАЖ НӨЛӨӨНИЙ ХЯНАЛТ

| № | Огноо      | Гаж нөлөө          | Эмчилгээний горим | Хийгдэх эмчилгээ                 | Эмчилгээний шинэ горим | Гаж нөлөө арилсан огноо | Зөвлөгөө                                 |
|---|------------|--------------------|-------------------|----------------------------------|------------------------|-------------------------|--|
| 1 | 2008/11/05 | Эм уугаад бөөлжинө | 6 S Ofi Z EthCs   | Цервикал 0,5 x 3 уух<br>14 хоног | =                      |                         | Бөөлжилт багассан боловч бүрэн арилаагүй |

|   |                |                         |                 |  |                      |   |
|---|----------------|-------------------------|-----------------|--|----------------------|---|
| 2 | 2008/12/10     | Тайван биш,<br>уцаартай | 6 S Ofi Z EthCs | Вит В6 тарих,<br>амилтриптилин<br>уулгах | =                    | Ажиглах,<br>сэтгэцийн<br>эмчид 7 хоног<br>тутам үзүүлж<br>зөвлөгөө авах |
| 3 | 2009<br>/02/25 | Сэтгэл<br>гутрал        | 6 S Ofi Z EthCs | Эмчилгээний<br>горим солих               | 6 Km Ofi Z<br>EthPas | Эмч нарын<br>зөвлөгөөнөөр<br>оруулж<br>эмчилгээний<br>горим солих       |

## 6. ЭМЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮНГ ТООЦОХ

Эмэнд мэдрэг сүрьеэтэй өвчтөний эмчилгээний үр дүнг тооцохтой ижил эдгэрсэн, эмчилгээ дууссан, эмчилгээ үр дүнгүй, нас барсан, эмчилгээ тасалсан, шилжсэн гэсэн үзүүлэлтээр ОЭДС-тэй өвчтөний эмчилгээний үр дүнг гаргана. Гэхдээ тодорхойлолтын хувьд бага зэрэг ялгаатай

Эмчилгээний үр дүнгийн тодорхойлолт

| Эмчилгээний үр дүн | Тодорхойлолт   |
|--------------------|--|
| Эдгэрсэн           | Эмчилгээний сүүлийн 12 сарын хугацаанд доод тал нь 30 хоногийн зайтай хийсэн төгсгөлийн 5 удаагийн өсгөвөрлөх шинжилгээ дараалан сөрөг гарсан тохиолдлыг 3-4 өсгөвөр дараалан сөрөг, эмнэл зүйл хувьд сайжирсан тохиолдлыг                     |
| Эмчилгээ дууссан   | Эмчилгээ бүрэн хийлгэсэн, эмчилгээний төгсгөлд өсгөвөр сөрөг доорхи тохиолдлыг<br>Эмчилгээ хяналтын шинжилгээ бүрэн хийгдээгүй<br>3-4 өсгөвөр дараалан сөрөг, эмнэл зүйн хувьд сайжраагүй<br>Уушгины түрхэц сөрөг, уушгины бус эрхтэний сүрьеэ |
| Нас барсан         | Эмчилгээний хугацаанд ямар нэг шалтгаанаар нас барсан тохиолдлыг   |
| Эмчилгээ тасалсан  | Эмчилгээний хугацаанд 2 сар түүнээс дээш хугацаанд эмчилгээ тасалсан тохиолдлыг  |
| Үр дүнгүй          | ийн 3 удаагийн өсгөвөрлөх шинжилгээний 1-ээс<br>1 тохиолдол өсгөвөр зэрэг гарсан тохиолдлыг  |
| Шилжсэн            | илгээний хугацаанд өөр аймаг, дүүрэгт шилжсэн<br>олдлыг  |

“ОЭДС-тэй өвчтөний эмчилгээний асуудал шийдвэрлэх зөвлөгөөн” өөр оруулж эмчилгээний үр дүнг тооцож хяналтаас хасах асуудлыг шийдвэрлэсний дараа “ОЭДС-тэй өвчтөнийг бүртгэх маягт ОЭДС-03” – ын 5 дахь нүүрэнд байх хүснэгтэд асуултын дагуу бичнэ.

| No | Эмчилгээний үр дүн огноо |                    |           |            |                   |         | Тайлбар |
|----|--------------------------|--------------------|-----------|------------|-------------------|---------|---------|
|    | Эдгэрсэн                 | Эмчилгээ дуусгасан | Үр дүнгүй | Нас барсан | Эмчилгээ тасалсан | Шилжсэн |         |
| 1  | <i>Эдгэрсэн</i>          |                    |           |            |                   |         |         |
|    | 2010 /02 /22             |                    |           |            |                   |         |         |
| 2  |                          |                    |           |            |                   |         |         |
|    | / /                      |                    |           |            |                   |         |         |
| 3  |                          |                    |           |            |                   |         |         |
|    | / /                      |                    |           |            |                   |         |         |

Мөн "ОЭДС-тэй өвчтөний эмчилгээ, хяналтын карт ОЭДС-01"-ын 7 дахь нүүрийн баруун доод хэсэгт байх эмчилгээний үр дүн гэсэн хүснэгтэд гарсан үр дүнг хяналтаас гарсан он сар өдрийн хамт бичнэ.

| Үр дүн             | ✓ | Огноо             |
|--------------------|---|-------------------|
| Эдгэрсэн           | ✓ | <b>2010/02/22</b> |
| Эмчилгээ дуусгасан |   | / /               |
| Нас барсан         |   | / /               |
| Үр дүнгүй          |   | / /               |
| Эмчилгээ тасалсан  |   | / /               |
| Шилжсэн            |   | / /               |

### ОЭДС-ИЙН ТАЙЛАН МЭДЭЭ

Хяналт шинжилгээ нь үйл ажиллагаа төлөвлөгдсөний дагуу биелэгдэж байгаа эсэхэд хяналт тавих үйл явц юм. ОЭДС-тэй өвчтөнийг оношлох, эмчлэх, хянах явцад тулгарч буй бэрхшээлийг тодорхойлж улмаар шийдвэрлэх арга замыг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх, туслахад хяналт шинжилгээний гол зорилго оршино. Тайлан мэдээ гаргах нь хяналт шинжилгээний ажлын нэг хэсэг бөгөөд хөтлөгдөж буй бүртгэл маягтуудтай танилцах, шаардлагатай тоо баримтыг цуглуулах, тайлангийн маягтыг бөглөж тайлан гаргах зэргээс бүрдэнэ.

#### 1. ОЭДС- 07 Бүртгэгдсэн ОЭДС-тэй өвчтөний улирлын тайлан

ОЭДС-ийн сэжигтэй тохиолдол, ЭМЧ тодорхойлох шинжилгээнд орж ОЭДС-тэй нь тогтоогдсон тохиолдол, эдгээрээс эмчилгээнд орсон хүмүүсийн тайланг гаргах нь тайлан мэдээний хамгийн гол хэсэг бөгөөд илрүүлэлтийг тогтооход чухал ач холбогдолтой.

Сар, улирлын мэдээг тухайн сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон сүрьеэгийн дүн бүртгэл хариуцсан бага эмч /сувилагч/ гаргаж, сүрьеэгийн зохицуулагч эмч хянаад гарын үсэг зуран баталгаажуулж дараа сарын эхний 5 хоногт багтаж сүрьеэгийн тандалт судалгааны албанд явуулна.

"ОЭДС-тэй нь тогтоогдсон өвчтөний улирлын тайлан ОЭДС 07" маягт нь 3 хүснэгтээс бүрдэнэ.





### Хүснэгт 3: ОЭДС-тэй нь тогтоогдож эмчилгээ эхэлсэн өвчтөн нас, хүйсээр

Энэ хүснэгтэд эмчилгээ эхэлсэн өвчтөнийг нас, хүйсээр нь ангилж бичнэ.

Хүснэгт 3

|    | 0-14 | 15-24 | 25-34 | 35-44 | 45-54 | 55-64 | 65+ | Бүгд |
|----|------|-------|-------|-------|-------|-------|-----|------|
| Эр |      |       |       |       |       |       |     |      |
| Эм |      |       |       |       |       |       |     |      |

Хүснэгт 2,3-д бүгд гэж дүгнэгдсэн өвчтөний тоо нь Хүснэгт 1-ийн V багананд буй тоотой таарч байхыг анхаарна.

### 2. ОЭДС- 08 Эмчилгээний 6 дахь сарын үр дүнгийн тайлан

ОЭДС-тэй өвчтөний эмчилгээний үр дүнг эмчилгээний явцад хийгдсэн түрхэцийн болон өсгөврийн шинжилгээгээр хянадаг. Эмчилгээний эрчимт шат буюу эхний 6 сард сар бүр, үргэлжлэх шатанд 2 сар тутам түрхэц ба өсгөврийн шинжилгээ хийнэ. Хэрэв эмчилгээний эхний 6 дахь сард өсгөвөр сөрөг болохгүй бол өсгөврийн хариу сөрөг гарах хүртэл сар бүр цэрний шинжилгээ хийнэ.

ОЭДС-08 нь эрчимт эмчилгээний шатны эмчилгээний үр дүнг гаргах тайлан бөгөөд тухайн улиралд бүртгэгдэж эмчилгээнд орсон өвчтөний тайлан 9 сарын дараа гарна. Жишээ нь: 2008 оны 1-р улиралд бүртгэгдэж эмчилгээнд орсон өвчтөний 6 сарын дараах эмчилгээний үр дүнгийн тайлан 9 сарын дараа буюу 2008 оны 4-р улирлын эцэст гарна.

Тайлангийн хүснэгт нь 3 баганаас бүрдэнэ.

1-р баганад тухайн улиралд бүртгэгдэж эмчилгээнд орсон хүний тоог ОЭДС-03 маягтаас харж бичнэ.

2-р баганад эмчилгээний 6 дахь сарын өсгөвөр, түрхэцийн хариуг ОЭДС-03 маягтаас харж бичих ба энэ багана нь өсгөвөр сөрөг, өсгөвөр эерэг, өсгөврийн шинжилгээ хийгдээгүй гэсэн 3 баганад хуваагдана. Өсгөвөр сөрөг, өсгөвөр эерэг гэсэн 2 багана нь түрхэц сөрөг, түрхэц эерэг гэсэн баганад мөн хуваагдана.

|                               | Эмчилгээ эхэлсэн тохиолдлын тоо | Эмчилгээний 6 дахь сарын өсгөвөр, түрхэцийн шинжилгээний хариу |              |               |              |                                |
|-------------------------------|---------------------------------|--|--------------|---------------|--------------|--------------------------------|
|                               |                                 | Өсгөвөр сөрөг  |              | Өсгөвөр эерэг |              | Өсгөврийн шинжилгээ хийгдээгүй |
|                               |                                 | Түрхэц сөрөг   | Түрхэц эерэг | Түрхэц сөрөг  | Түрхэц эерэг |                                |
| ОЭДС-тэй болох нь тогтоогдсон |                                 |  |              |               |              |                                |
| ОЭДС-тэй байж болзошгүй       |                                 |  |              |               |              |                                |
| Бүгд                          |                                 |  |              |               |              |                                |

ОЭДС-ийн эмчилгээ хийлгэж байгаа өвчтөний 60% орчим нь эмчилгээний 6 дахь сарын төгсгөлд өсгөвөр сөрөг гардаг зүй тогтнол байдаг. Зарим шалтгаанаар 6 дахь сарын өсгөврийн шинжилгээ хийгдээгүй байдаг ба 3-р баганад эдгээр өвчтөнг шалтгаанаар нь ангилан бичнэ.

| Шинжилгээ хийгдээгүй шалтгаан |          |                         |         |                |
|-------------------------------|----------|-------------------------|---------|----------------|
| Нас барсан                    | тасалсан | Эмчилгээнээс татгалзсан | шилжсэн | Эм тохиороогүй |



|                               |  |  |  |  |  |  |  |  |
|-------------------------------|--|--|--|--|--|--|--|--|
| I бүлгийн эмчилгээ үр дүнгүй  |  |  |  |  |  |  |  |  |
| II бүлгийн эмчилгээ үр дүнгүй |  |  |  |  |  |  |  |  |
| Шилжиж ирсэн                  |  |  |  |  |  |  |  |  |
| бусад                         |  |  |  |  |  |  |  |  |
| бүгд                          |  |  |  |  |  |  |  |  |

ОЭДС-ийн эмчилгээ 18-24 сар үргэлжилдэг учир өвчтөн эмчилгээнд орсноос 27 сар буюу 2 жил 3 сарын дараа эмчилгээний үр дүнгийн тайлан гарна. Жишээ нь : 2008 оны 3-р улиралд эмчилгээнд орсон хүний эмчилгээний үр дүнгийн тайлан 2010 оны 4-р улиралд гарна.

### **ОЭДС-тэй өвчтөний эмчилгээний асуудал шийдвэрлэх эмч нарын зөвлөгөөн**

ЭМС-ын 2009 оны 397-р тушаалын 3-р хавсралтын 6-д заагдсан бүрэлдэхүүн бүхий "ОЭДС-тэй өвчтөний эмчилгээний асуудал шийдвэрлэх зөвлөгөөн"-өөр дараах асуудлыг шийдвэрлэнэ.

1. ОЭДС-тэй нь лабораторийн аргаар оношлогдсон өвчтөнийг эмчилгээнд оруулах
2. Эмнэлгээс гаргах
3. Эмчилгээний явцад ямар нэг шалтгаанаар горим солих /эм хасах, нэмэх/
4. Эмчилгээний 6 дахь сар болон эмчилгээний төгсгөлд эмчилгээний үр дүнг тооцох
5. Эмчилгээг зогсоох, эмчилгээ эхлэхээс татгалзах /өвчтөн өөрөө татгалзсан, биеийн байдлаас болсон г.м/

#### **Өвчтөнийг эмчилгээнд оруулах:**

Лабораторийн шинжилгээгээр олон эмэнд дасалтай сүрьеэгээр өвчилсөн болох нь батлагдсан тохиолдлыг "ОЭДС-тэй өвчтөний эмчилгээний асуудал шийдвэрлэх эмч нарын хамтарсан зөвлөгөөн" өөр оруулж эмчилгээний асуудлыг шийдвэрлэнэ. Үндэсний түвшинд эмч нарын хамтарсан зөвлөгөөнийг 14 хоногт нэг удаа зохион байгуулна. Хэрэв шаардлагатай тохиолдолд (өвчтөний биеийн байдал хүнд, гаж нөлөө хүчтэй илэрсэн г.м) эмч нарын хамтарсан ээлжит бус зөвлөгөөн хийж асуудлыг шийдвэрлэнэ.

ОЭДС-тэй өвчтөнийг эмчилгээнд анх оруулахад хавсралт 1-ийн дагуу танилцуулгыг компьютерээр товч, тодорхой бичиж, зөвлөгөөний гишүүдийн тоогоор 11 ширхэг хувилж бэлтгэж ирнэ.

ОЭДС-тэй өвчтөнийг эмчилгээнд анх оруулахад доорхи шинжилгээнүүдийг хийж дүгнэлт гаргасан байна. Үүнд:

1. Өсгөвөр, эмийн мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ
2. Түрхэцийн шинжилгээ
3. Гэрлийн шинжилгээ (цээжний том зураг)
4. Цусны дэлгэрэнгүй шинжилгээ
5. Элэгний үйл ажиллагааны сорил
6. Шээсний ерөнхий шинжилгээ
7. Бамбай булчирхайн дааврын шинжилгээ

8. Хараа зүйн үзлэгийн дүгнэлт
9. Сонсголын бичлэг, түүний дүгнэлт
10. Төрөх насны эмэгтэйчүүдэд жирэмснийг тодорхойлох сорил тавиулах
11. Өвчтөний хавьтлын урьдчилан сэргийлэх үзлэгт оруулсан мэдээлэл
12. Эмэнд дасалтай сүрьеэгийн эмчилгээнд оруулахад өвчтөн болон гэр бүлийн гишүүн нь ЭДС-ийн эмчилгээ хийлгэхийг зөвшөөрсөн байна.

ОЭДС-тэй өвчтөн түүний гэр бүлд энэ өвчний болон эмчилгээний талаар тодорхой мэдээлэл өгч, оршин суух хаягийг тодорхой болгож зөвлөгөөнд оруулна.

Хавсралт 1-ийн дагуу танилцуулга бичихдээ ямар мэргэжилтэй, хаана ямар байгууллагад хэдэн жил ажилласан, одоо ажиллаж байгаа эсэх талаар тодорхой бичнэ.

Өвчний оношийг тавихдаа сүрьеэгийн оношлогоо, эмчилгээний удирдамж стандартын дагуу бичнэ.

Өвчтөний өмнө хийлгэж байсан сүрьеэгийн эмчилгээний үр дүнгийн талаарх мэдээлэлийг СТСА-ны төвлөрсөн бүртгэлээс шүүлгэж бичсэн байна.

Өвчтөний хавьтал (аав, ээж, эмээ, өвөө, ах, эгч, дүү, хамаатан садан, хүргэн, бэр, ангийн найз гэх мэт)-ын талаарх өвчлөлийн мэдээллийг өөрөөс нь болон гэр бүлийн гишүүдээс нь сайн асууж тодорхой бичнэ. Хэрэв сүрьеэгээр өвчилсөн хүн байвал овог нэр, нас хүйс, өвчтөний хэн болох, хэдэн онд ямар хэлбэрийн сүрьеэгээр өвчилсөн, эмчилгээний үр дүн, тавиланг тодорхой бичсэн байна.

Бүх шинжилгээний үзүүлэлтийг тодорхой бичиж өөрчлөлт байгаа бол ямар үзүүлэлт, ямар өөрчлөлтэй байгаа талаар тодорхой бичнэ. Хэрэв шинжилгээний үзүүлэлтэнд өөрчлөлт гараагаагүй бол өөрчлөлтгүй, хэвийн гэж бичнэ.

Гэр бүлийн гишүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байдал гэдэгт ам бүл хэд, үүнээс хэн, хэдэн настай, сорил тавиулсан бол хэмжээ, рентген зураг, цэрний шинжилгээ авсан бол өөрчлөлт байгаа эсэх талаар тодорхой бичсэн байна.

Нэмэлт мэдээлэл гэдэгт энэ танилцуулгын маягтанд ороогүй бусад хавсарсан өвчний талаарх мэдээллийг оруулна.

Зөвлөгөөний шийдвэрийн төсөл гэдэгт өвчтөнг яагаад олон эмэнд дасалтай сүрьеэгийн эмчилгээнд оруулах болсон үндэслэл болон эмч нарын хамтарсан зөвлөгөөнөөр ямар шийдвэр гаргуулах гэж байгаа талаар бичсэн байна.

Танилцуулга бичсэн эмч гарын үсгээ зурж он, сар, өдрийг бичиж баталгаажуулна.

**Эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөний эмчилгээний асуудал шийдвэрлэх эмч нарын хамтарсан зөвлөгөөнд хэлэлцүүлэх өвчтөний танилцуулга**  
(Олон эмэнд дасалтай сүрьеэгийн эмчилгээнд шинээр оруулах үйлчлүүлэгч)

**2008 оны 08 сар 13 өдөр**

|   |   |
|---|---|
| Өвчтөний овог нэр   | <i>Дашдорж Уранчимэг</i>  |
| Нас, хүйс   | <i>32 эмэгтэй</i>   |
| Гэрийн хаяг   | <i>УБ хот, СХД-ийн 18-р хороо, 30-р хороолол, 5-р байр 3-66 тоот</i>  |
| Ам бүл  | <i>4, нөхөр, охин, ээж</i>  |
| Мэргэжил  | <i>Нягтлан бодох</i>  |
| Ажил, сургуулийн хаяг   | <i>805-р дэлгүүрт нягтлан бодох</i>   |
| Биеийн жин  | <i>68 кг</i>  |
| Онош  | <i>Баруун уушигны дээд дэлбэнгийн хөндийт сүрьеэ, задралын үедээ, ХТН/+</i>   |
| Анамnes morbi-д өмнөх эмчилгээний талаарх мэдээлэл (СТСА-ны төвлөрсөн бүртгэлээс шүүлгэсэн байх)                                    | <i>2004 оны 1-р сарын 24-нд баруун уушигны дээд дэлбэнгийн нэвчдэст сүрьеэ, ХТН/+ оношоор 1-р бүлгийн эмчилгээнд орж 6 сар эмчлүүлэн 7-р сарын 30 нд эмчилгээ дууссанаар хяналтаас хасагдсан.</i> |
| Эпиданамнез (өвөө, эмээ, аав, ээж, ах дүү, хамаатан, садан төрлөөс нь сүрьеэгээр өвчилсөн эсэх) өвчилж байсан хүнийг тодорхой бичих | <i>Дүү Дашдоржийн Ганбат нь Сүрьеэгийн менингит оношоор 2001 онд эмчлэгдэж эмчилгээ дуусгасан</i>   |
| Одоогийн бодит үзлэгээр биеийн байдал   | <i>Биеийн байдал хүндэвтэр, хурдан явахад амьсгаадна, ханиалгана гэсэн зовиуртай</i>  |
| Лабораторийн шинжилгээний дүгнэлт   | <i>Клиникийн болон биохимийн шинжилгээнд өөрчлөлтгүй, үйл ажиллагааны бусад шинжилгээнд өөрчлөлтгүй, эмийн мэдрэг чанар тодорхойлох шинжилгээгээр ОЭДС-тэй нь тогтоогдсон</i>                     |
| Түрхэцийн шинжилгээний хариу  | <i>2008.05.14 №4511, эерэг</i>  |
| Өсгөврийн шинжилгээний хариу  | <i>2008.06.20, № 4511, эерэг</i>  |
| Эмийн мэдрэг чанар тодорхойлох шинжилгээний хариу   | <i>2008.08.05, S,H,R –Д, E – M.</i>   |
| Сүүлчийн биохимийн шинжилгээний хариу   | <i>Билирубин - 16,0: нийт уураг- 72,9: альбумин - 39,7: АСАТ 17,9: АЛАТ 21,4, кали -6,4, креатинин -0,5</i>   |
| Сүүлчийн цусны дэлгэрэнгүй шинжилгээний хариу   | <i>СОЭ 22мм/ц, лейкоцит – 8,0 x10<sup>9</sup> л, гемоглобин – 120 г/л, эритроцит – 5,5 x 10<sup>12</sup>л</i>   |
| Гэрлийн шинжилгээний хариу (сүүлчийн 14 хоног)  | <i>Баруун уушигны дээд дэлбэнд 3-5 см хэмжээтэй хөндийтэй, 2 талын уушигнд зөөлөн ба хатуу голомтот сүүдэртэй</i>   |
| <u>Сонсголын бичлэг</u>   | <u><i>хэвийн</i></u>  |
| Хараа зүйн үзлэг  | <i>OD-08, OS-09, гэрлийн систем тунгалаг, нүдний угт өөрчлөлтгүй</i>  |
| Бамбай булчирхай (изотопи шинжилгээ Т3-Т4 даавар)   | <i>Т3 -3,56, Т4 – 15,26, TSH – 1,16</i>   |

|   |  |
|---|--|
| Гэр бүлийн гишүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байдал | <i>Нөхөр Б.Бат 36 настай, 2008.08.10 – флюор № 1225, өөрчлөлтгүй охин Б.Оюун 8 настай, 2008.08.10 туберкулины сорил 3 мм ээж Д.Дулмаа 65 настай, 2008.08.10 – флюор №1226, өөрчлөлтгүй</i> |
| Нэмэлт мэдээлэл   | <i>2006 оноос чихрийн шижин өвчнөөр өвчилсөн, 2007 оноос инсулины хамааралд орсон</i>  |
| Зөвлөгөөний шийдвэрийн төсөл                                      | <i>Эмийн мэдрэг чанар тодорхойлох шинжилгээний хариунд үндэслэн ОЭДС-ийн эмчилгээнд оруулах</i>  |

Танилцуулга бичсэн...**Наран...**( А.Наран )

**Эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөний эмчилгээний асуудал шийдвэрлэх эмч нарын хамтарсан зөвлөгөөнд хэлэлцүүлэх өвчтөний танилцуулга**  
(Олон эмэнд дасалтай сүрьеэгийн эмчилгээнд шинээр оруулах үйлчлүүлэгч)

**2008 оны 10 сар 11 өдөр**

|   |  |
|---|--|
| Өвчтөний овог нэр   | <i>Нэргүй Намсрай</i>  |
| Нас, хүйс   | <i>48 эрэгтэй</i>  |
| Гэрийн хаяг   | <i>УБ хот, СХД-ийн 3-р хороо, Байшингийн 160-р гудамж 558 тоот</i>   |
| Ам бүл  | <i>3, эхнэр, хүү</i>   |
| Мэргэжил  | <i>жолооч</i>  |
| Ажил, сургуулийн хаяг   | <i>«Уянга ХХК-д жолооч»</i>  |
| Биеийн жин  | <i>72 кг</i>   |
| Онош  | <i>2 талын уушигны дээд дэлбэнгийн сорвит хөндийт сүрьеэ, задралын үедээ, ХТН/+, амьсгалын дутагдал 2-р үе</i>   |
| Анамnes morbi-д өмнөх эмчилгээний талаарх мэдээлэл (СТСА-ны төвлөрсөн бүртгэлээс шүүлгэсэн байх)                                    | <i>2007 оны 12-р сарын 24-нд зүүн уушигны дээд дэлбэнгийн нэвчдэст сүрьеэ, ХТН/+ оношоор 1-р бүлгийн эмчилгээнд орж 2008 оны 05-р сарын 20 нд хийгдсэн эмчилгээний 5 дахь сарын хяналтын түрхэцийн шинжилгээ эерэг гарсан учир 1-р бүлгийн эмчилгээ үр дүнгүйгээр эмчилгээ зогсоож 2-р бүлгийн эмчилгээнд 05-р сарын 31 нд орсон. Одоо 2-р бүлгийн эмчилгээ хийгдэж байгаа</i> |
| Эпиданамнез (өвөө, эмээ, аав, ээж, ах дүү, хамаатан, садан төрлөөс нь сүрьеэгээр өвчилсөн эсэх) өвчилж байсан хүнийг тодорхой бичих | <i>Байхгүй</i>   |
| Одоогийн бодит үзлэгээр биеийн байдал   | <i>Биеийн байдал хүндэвтэр, хурдан явахад амьсгаадна, ханиалгана, цустай цэр гарна оройд халуурна гэсэн зовиуртай</i>  |
| Лабораторийн шинжилгээний дүгнэлт   | <i>Цусны ерөнхий шинжилгээнд архаг цус багадалттай, эмийн мэдрэг чанар тодорхойлох шинжилгээгээр ОЭДС-тэй нь тогтоогдсон</i>   |
| Түрхэцийн шинжилгээний хариу  | <i>2008.06.07 №4569, эерэг</i>   |
| Өсгөврийн шинжилгээний хариу  | <i>2008.07.09, № 4569, эерэг</i>   |
| Эмийн мэдрэг чанар тодорхойлох шинжилгээний хариу   | <i>2008.10.01, E, H, R – Д, S – M.</i>   |
| Сүүлчийн биохимийн шинжилгээний хариу   | <i>Билирубин - 19,0: нийт уураг- 72,9: альбумин - 39,7: АСАТ 17,9: АЛАТ 21,4, кали -6,4, креатинин -0,5</i>  |

|   |   |
|---|---|
| Сүүлчийн цусны дэлгэрэнгүй шинжилгээний хариу                     | <i>СОЭ 14 мм/ц, лейкоцитит – 8,5 x 10<sup>9</sup> л, гемоглобин – 85 г/л, эритроцит – 2,5 x 10<sup>12</sup>л</i>                                |
| Гэрлийн шинжилгээний хариу (сүүлчийн 14 хоног)                    | <i>2 талын уушигны дээд дэлбэнд зөв биш хэлбэртэй хөндийтэй, 2 талын уушгинд хатуурсан сорвижилт үүссэн, зүрхний сүүдэр зүүн дээш татагдсан</i> |
| Сонсголын бичлэг  | <i>хэвийн</i>   |
| Хараа зүйн үзлэг  | <i>OD-08, OS-09, гэрлийн систем тунгалаг, нүдний угт өөрчлөлтгүй</i>  |
| Бамбай булчирхай (изотопи шинжилгээ T3-T4 даавар)                 | <i>T3 -2,33, T4 – 14,26, TSH – 1,0</i>  |
| Гэр бүлийн гишүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байдал | <i>Эхнэр Ж.Гэрэл 46 настай, 2008.10.08 – флюор № 1771, өөрчлөлтгүй<br/>хүү Н.Эдэнэ 25 настай, 2008.10.08 – флюор № 1772, архаг бронхит</i>      |
| Нэмэлт мэдээлэл   | <i>Уурхайд 20 жил ажилласан, уушиг тоосжих өвчний улмаас тахир дутуугийн групп-д орсон</i>  |
| Зөвлөгөөний шийдвэрийн төсөл                                      | <i>Эмийн мэдрэг чанар тодорхойлох шинжилгээний хариунд үндэслэн ОЭДС-ийн эмчилгээнд оруулах</i>   |

Танилцуулга бичсэн...**Наран...**(А.Наран)

**Өвчтөнийг эмнэлгээс гаргах:**

ОЭДС-тэй өвчтөнийг эмнэлгээс гаргах үед хавсралт 2-ийн дагуу танилцуулга бичнэ. Манай орны нөхцөлд ОЭДС-тэй өвчтөний эрчимт эмчилгээний шатыг 6 сар хийж эмнэлгээс гаргах ерөнхий зарчим баримталдаг боловч доорхи шаардлага хангасан байх шаардлагатай. Үүнд:

1. Өсгөвөрлөх шинжилгээ дараалан 2 удаа сөрөг болсон
2. Түрхэцийн шинжилгээ сөрөг болсон
3. Эмийн зохимж сайн, гаж нөлөө бага
4. Биеийн байдал дунд, эмнэлзүйн сайжрал өгсөн
5. Гэрлийн шинжилгээнд динамик сайжрал гарсан
6. ОЭДС-ийн тасагт 4-6 сар эмчлэгдсэн
7. ОЭДС-ийн тасагт 8 сар эмчлүүлсэн боловч түрхэц, өсгөвөрийн шинжилгээ сөрөгт шилжээгүй хүнд тохиолдол

Өвчтөний жинг сар бүр үзсэн байдлыг тэмдэглэхээс гадна хэрэв жин буурсан байвал шалтгааныг маш тодорхой бичиж дүгнэлт гаргасан байна..

Эмнэлгээс гаргах өвчтөний түрхэцийн болон өсгөвөрлөх шинжилгээнд дүгнэлт бичсэн байна.

Эмийн гаж нөлөөний илрэл гэсэн хэсэгт эмнэлэгт хэвтэх хугацаанд ямар эмийн гаж нөлөөний улмаас ямар эмнэлзүй, зовиур шаналгаа гарсан, энэ гаж нөлөөний илрэлийг арилгах, бууруулах зорилгоор ямар эмчилгээг, ямар хугацаанд хийсэн, цаашид аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерийн эмч юу анхаарах талаар бичнэ.

Уушгины зурагт гарсан өөрчлөлт гэсэн хэсэгт өвчтөн эмчилгээнд анх орох үед уушгинд ямар өөрчлөлт байсан эмчилгээний явцад уг өөрчлөлт ямар болсон талаар бичнэ.

Нэмэлт мэдээлэл гэсэн хэсэгт чихрийн шижин, сэтгэцийн тулгамдсан асуудал, элэг, бөөрний эмгэгийн талаар гэх мэт оруулж бичнэ

Зөвлөгөөний шийдвэрийн төсөл гэсэн хэсэгт эмнэлгээс гаргах болсон үндэслэлийг тодорхой бичсэн байна.

“ОЭДС-ийн эмчилгээний асуудал шийдвэрлэх зөвлөгөөн” - өөр орсон тохиолдол бүрд “ОЭДС-тэй өвчтөний эмчилгээ, хяналтын карт ОЭДС-01”- ын эхний нүүрэнд байх “Эмч нарын зөвлөгөөний шийдвэр” нүдэнд зохих асуултын дагуу бичилт хийнэ.



Хавсралт 2

**ОЭДС-тэй өвчтөнийг эмнэлгээс гаргах танилцуулга**

2009. оны.02.сар.15.өдөр

1. Өвчтөний овог нэр **Дашдорж Уранчимэг**
2. Нас, хүйс **33 эмэгтэй**
3. Гэрийн хаяг: **УБ хот, СХД-ийн 18-р хороо, 30-р хороолол, 5-р байр 3-66 тоот**
4. Эмчилгээ эхэлсэн .**2008.он.08.сар.15.өдөр**
5. Биеийн жин: **0 сар – 68кг, 1 сар – 66кг, 2 сар – 66 кг, 3 сар – 67кг, 4 сар – 69кг, 5 сар – 70кг, 6 сар – 72кг**
6. Ор хоног: **180**
7. Онош: **Баруун уушигны дээд дэлбэнгийн хөндийт сүрьеэ, шимэгдэлтийн үедээ, ХТН-I**
8. Түрхэцийн шинжилгээний хариу: **0 сар - №4511 эерэг, 1 сар - №5956 эерэг, 2 сар – 6023 сөрөг, 3 сар – 6192 сөрөг, 4 сар – 6260 сөрөг, 5 сар – 6382 сөрөг, 6 сар – 6490 сөрөг**
9. Өсгөврийн шинжилгээний хариу: **0 сар - №4511 эерэг, 1 сар - №5956 эерэг, 2 сар – 6023 сөрөг, 3 сар – 6192 сөрөг, 4 сар – 6260 сөрөг, 5 сар – 6382 сөрөг, 6 сар – хариу гараагүй**
10. Эмийн гаж нөлөөний илрэл: **эмчилгээний эхний 2 сард эм уусны дараа дотор муухайрах шинж тэмдэг гарч байсан боловч гаж нөлөөний эсрэг мөн нэмэлт эмчилгээний дүнд 3 дахь сараас арилсан.**
11. Уушгины зурагт гарсан өөрчлөлт: **баруун уушигны орой хэсэгт байсан хөндий шимэгдэж 0,5 х 1,5 см орчим болсон, 2 талын уушгинд байсан зөөлөн сүүдрүүд шимэгдсэн**
12. Нэмэлт мэдээлэл: **эмчилгээний хугацаанд 14 хоног бүрдотоод шүүрлийн эмгэгийн эмчид үзүүлж зөвлөгөө авч, инсулин эмчилгээг тогтмол хийлгэсэн.**
13. Зөвлөгөөний шийдвэрийн төсөл: **бодит үзлэг, цэрний болон уушигны гэрлийн шинжилгээний хариунд үндэслэн Эрчимт шатны эмчилгээг дуусган эмнэлгээс гаргаж харьяа дүүргийн сүрьеэ диспансерийн хяналтанд үргэлжлэх шатны эмчилгээг 180fl Z Eth Cs горимоор эхлүүлэх**

Танилцуулга бичсэн: Эмчлэгч эмч...**Дэлгэр**.....( Дэлгэр)

### **Өвчтөний эмчилгээний горим солих**

Ихэнх тохиолдолд эмчилгээний явцад гарсан эмийн гаж нөлөөний улмаас горим сольдог ба энэ үед хавсралт 3-ын дагуу танилцуулга бичиж "ОЭДС-тэй өвчтөний эмчилгээний асуудал шийдвэрлэх зөвлөгөөн" – өөр оруулна.

Дээрх жишээ дээр өвчтөн эрчимт шатны эмчилгээ дуусаж эмнэлгээс гараад үргэлжлэх шатны эмчилгээнд орох учир горим солих маягтыг бичих шаардлагагүй зөвхөн зөвлөгөөний шийдвэр дээр бичихэд болно.

Хэрэв "ОЭДС-тэй өвчтөний эмчилгээний асуудал шийдвэрлэх эмч нарын зөвлөгөөн" - өөр эмчилгээний горим сольсон бол "ОЭДС-тэй өвчтөний эмчилгээ, хяналтын карт ОЭДС-01"-ын 2 дахь нүүрэнд байх IV бүлгийн эмчилгээний горим хүснэгтэд зохих асуултын дагуу бичилт хийнэ.

Хавсралт 3

### **ОЭДС-тэй өвчтөний эмчилгээний горим солих танилцуулга**

**2009** оны **02** сар **18** өдөр

1. Өвчтөний овог нэр: **Нэргүй Намсрай**
2. Нас, хүйс: **49 эрэгтэй**
3. Гэрийн хаяг: **УБ хот, СХД-ийн 3-р хороо, Байшингийн 160-р гудамж 558 тоот**
4. Эмчилгээ эхэлсэн **2008** он **10** сар **18** өдөр
5. Эмчилгээний хэд дэх сар **4 дэх сар**
6. Биеийн жин: **0 сар - 72кг, 1 сар - 65кг, 2 сар - 60 кг, 3 сар - 60кг, 4 сар - 60кг**
7. Онош: **2 талын уушигны дээд дэлбэнгийн сорвит хөндийт сүрьеэ, задралын үедээ, ХТНl+l, амьсгалын дутагдал 2-р үе**
8. Түрхэцийн шинжилгээний хариу: **0 сар - №4569 эерэг, 1 сар - №6056 эерэг, 2 сар - 6223 эерэг, 3 сар - 6345 эерэг, 4 сар - 6533 сөрөг**
9. Өсгөврийн шинжилгээний хариу: **0 сар - №4569 эерэг, 1 сар - №6056 эерэг, 2 сар - 6223 эерэг, 3 сар - 6345 эерэг, 4 сар - 6533 хариу гараагүй**
10. Эмийн гаж нөлөөний илрэл: **11-р сарын эхнээс эм уусны дараа бөөлждөг болсон, биеийн жин буурсан, гаж нөлөөний эсрэг эмчилгээний дүнд энэ зовиур багассан боловч бүрмөсөн арилаагүй, цочиромхой болсон, сонсгол муудаж байгаа**
11. Уушгины зурагт гарсан өөрчлөлт: **өөрчлөлт үгүй**
12. Нэмэлт мэдээлэл: **гаж нөлөөний эсрэг эмчилгээний дүнд бөөлжилт багассан боловч сэтгэцийн талын өөрчлөлт багасахгүй байгаа, мөн өсгөврийн шинжилгээ 3 сар дараалан эерэг байгаа**
13. Зөвлөгөөний шийдвэрийн төсөл: **зовиур болон эмчилгээний явцын хяналтын шинжилгээг үндэслэн эмчилгээний горимыг Km OfI Z Eth Pas болгон солих**

Танилцуулга бичсэн: Эмчлэгч эмч..**Б.Саран**..( Б.Саран )

**Өвчтөний эмчилгээний үр дүн тооцох**

Олон эмэнд дасалтай сүрьеэгийн эмчилгээний эрчимт шат 6-8 сар, үргэлжлэх шат 12-18 сар, нийт үргэлжлэх хугацаа 18-24 сар байна. Олон эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөний эмчилгээний үр дүнг эрчимт эмчилгээний төгсгөлд 4 дахь сарын, үргэлжлэх шатны төгсгөлд тус тус тооцох ба “ОЭДС-тэй өвчтөний эмчилгээний асуудал шийдвэрлэх эмч нарын зөвлөгөөн” – өөр хэлэлцүүлэхэд хавсралт 6-ын дагуу танилцуулга бичнэ.

Түрхэц, өсгөврийн шинжилгээнд дүгнэлт хийж бичнэ. Гэрлийн шинжилгээнд өвчтөн анх эмчилгээнд орох үеийн болон эмчилгээний явцад авсан, хамгийн сүүлд зөвлөгөөнд орохоос 14 хоногийн дотор авахуулсан зураг зэрэг 3-4 том зурагтай ирнэ. Уушгины зураг дахь эмгэг өөрчлөлтийн динамик ямар байгааг дүгнэлт хийж бичсэн байна.

Эмийн гаж нөлөөний илрэл гэсэн хэсэгт эмчилгээний явцад гарсан гаж нөлөө, тухайлбал сонсгол буурсан бол одоо ямар байгаа талаар бичнэ.

Зөвлөгөөний шийдвэрийн төсөл гэсэн хэсэгт эмчилгээний үр дүнг ямар байдлаар тооцуулах талаархи үндэслэлийг бичнэ. Эмчилгээний үр дүнг эдгэрсэн, эмчилгээ дуусгасан, нас барсан, эмчилгээ тасалсан, үр дүнгүй, шилжсэн алин болохыг тодорхой бичсэн байна.

Мөн эмчилгээ дууссанаас хойш 5 жилийн туршид жилд нэгээс доошгүй удаа гэрлийн шинжилгээ болон эмнэлзүйн хяналт хийлгэх талаар бичнэ.

Хавсралт 4

**Олон эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөний эмчилгээний үр дүнг хэлэлцүүлэх танилцуулга**

2010 оны 02 сар 20 өдөр

|  |  |
|--|--|
| Өвчтөний овог нэр                              | <i>Дашдорж Уранчимэг</i>   |
| Нас, хүйс                                      | <i>34 эмэгтэй</i>  |
| Гэрийн хаяг                                    | <i>УБ хот, СХД-ийн 18-р хороо, 30-р хороолол, 5-р байр 3-66 тоот</i>   |
| Биеийн жин                                     | <i>69 кг</i>   |
| Онош   | <i>Баруун уушигны дээд дэлбэнгийн сорвит хөндийт сүрьеэ, шимэгдэлтийн үедээ, ХТН/-/</i>                      |
| Эмчилгээ эхэлсэн он сар өдөр                   | <i>2008 оны 08-р сарын 15</i>  |
| Эмчилгээний хэд дэх сар                        | <i>18 дахь сар</i>   |
| Одоогийн бодит үзлэгээр биеийн байдал          | <i>Биеийн байдал дунд, зовиургүй</i>   |
| Түрхэцийн шинжилгээний хариу                   | <i>Эмчилгээний 0 ба 1 дэх сарын шинжилгээ эерэг түүнээс хойш хийсэн 11 шинжилгээ бүгд сөрөг хариу гарсан</i> |
| Өсгөврийн шинжилгээний хариу                   | <i>Эмчилгээний 0 ба 1 дэх сарын шинжилгээ эерэг түүнээс хойш хийсэн 10 шинжилгээ бүгд сөрөг хариу гарсан</i> |
| Гэрлийн шинжилгээний хариу (сүүлчийн 14 хоног) | <i>2010 оны 02 сарын 15 ны цээжний том зурганд баруун уушигны орой хэсэгт хатуурсан голомтот сүүдэртэй</i>   |

|                              |  |
|------------------------------|--|
| Эмийн гаж нөлөөний илрэл     | <i>Эрчимт эмчилгээний шатанд хоол боловсруулах эрхтний талаас дотор муухайрах, бөөлжих зэрэг зовиур илэрч байсан боловч эмчилгээний дүнд арилсан</i> |
| Нэмэлт мэдээлэл              | <i>Чихрийн шижин өвчтэй, эмчилгээний явцад дотоод шүүрлийн булчирхайн эмчийн хяналтанд давхар хянагдаж инсулин эмчилгээг хийлгэж байсан</i>          |
| Зөвлөгөөний шийдвэрийн төсөл | <i>Бодит үзлэг, зовиур, шинжилгээний хариунд үндэслэн эмчилгээний үр дүнг эдгэрсэнээр тооцож эмчилгээнээс хасав</i>                                  |

Танилцуулга бичсэн. **А.Долгор** .( А.Долгор )

### Эмч нарын хамтарсан зөвлөгөөний шийдвэр:

“ОЭДС-тэй өвчтөний эмчилгээний асуудал шийдвэрлэх эмч нарын зөвлөгөөн” бүрд асуудал шийдвэрлүүлсэн өвчтөн бүрд хавсралт 5 – д заасан дагуу “Эмч нарын зөвлөгөөний шийдвэр бичнэ.

Эмч нарын зөвлөгөөний шийдвэрийг 3 хувь бичиж 1 хувийг аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерийн эмчлэгч эмч, 1 хувийг СТСА-ны тархвар судлаач, 1 хувийг ХӨСҮТ-ийн ОЭДС-ийн тасгийн эрхлэгч авч хурлын тэмдэглэл, тахвар судалгааны хуудас зэрэгт хавсаргана.

Хавсралт 5

### Олон эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөний эмч нарын зөвлөгөөний шийдвэр

Аймаг/дүүрэг: УБ хот, СХДүүрэг

Эмнэлэг: СХДүүргийн сүрьеэгийн диспансер

Эцэг/эх/-ийн нэр: Дашдорж Нэр Уранчимэг

Нас: 34 хүйс: Эрэгтэй/эмэгтэй

Гэрийн хаяг: СХД-ийн 18-р хороо, 30-р хороолол, 5-р байр 3-66 тоот

Эмчилгээний горим: 6Km Of1 Z EthCs/ 18Of1 Z Eth Cs

Эмчилгээ эхэлсэн огноо: 2008/08/15

Эмийн мэдрэг чанар тодорхойлох шинжилгээний хариу HRS - R; E - S

| № | Үндэслэл  | Шийдвэр  |
|---|---|--|
|   | <p>Эмчилгээ 18 сар хийгдсэн, үүнээс эрчимт эмчилгээ 6 сар, үргэлжлэх шатны эмчилгээ 12 сар хийгдсэн, эмчилгээний 0 ба 1 дэх сарын түрхэц, өсгөвөр аерэг, үүнээс хойш хийгдсэн эмчилгээ хяналтын 11 удаагийн түрхэц сөрөг, өсгөвөр сөрөг байсан.</p> <p>Биеийн байдал дунд, зовиургүй, эмчилгээгээ бүрэн хийлгэсэн</p> | <p>Эдгэрснээр эмчилгээний үр дүнг тооцож, үүнээс цааш 5 жилийн хугацаанд жилд нэгээс хоёр удаа гэрлийн болон эмнэлзүйн шинжилгээ хийлгэх</p> |

Гарын үсэг: \_\_\_\_\_

Огноо: 2010 он 02 сар 20 өдөр

**Эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйн хэм хэмжээ:**

Зарим тохиолдолд лабораториор ОЭДС-тэй нь батлагдсан өвчтөнөөс өөрийн болон гэр бүл ойр дотны хүмүүсийн хүсэлтээр эмчилгээнд орохоос татгалзах тохиолдол гардаг.

Энэ тохиолдолд “ОЭДС-тэй өвчтөний эмчилгээний асуудал шийдвэрлэх эмч нарын зөвлөгөөн” – өөр оруулж хавсралт 6-ийн дагуу мэдээллийг авна.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2006 оны “Эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйн хэм хэмжээ, ёс зүйн хорооны дүрэм, журам батлах тухай” 135 дугаар тушаалын долоодугаар хавсралтаар батлагдсан болно.

Хавсралт 6-ийн дагуу “Тусламж үйлчилгээнээс татгалзсан тухай хуудас”-ыг 3 хувь үйлдэж 1 хувийг үйлчлүүлэгч, 1 хувийг эмчлэгч эмч, 1 хувийг ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач эмчид өгнө.

Олон эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөн өөрөө эмнэлгээс гарах хүсэлт гаргасан тохиолдолд хавсралт 7-ийн дагуу “Өөрийн хүсэлтээр эмнэлгээс гарах тухай зөвшөөрлийн хуудас бичүүлнэ.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2006 оны 135 тоот тушаалын зургаадугаар хавсралтаар батлагдсан болно.

Хавсралт 7-ийн дагуу “Өөрийн хүсэлтээр эмнэлгээс гарах тухай зөвшөөрлийн хуудас”-ыг 3 хувь үйлдэж 1 хувийг үйлчлүүлэгч, 1 хувийг эмчлэгч эмч, 1 хувийг ХӨСҮТ-ийн СТСА-ны тархвар судлаач эмчид өгнө.

Хавсралт 6

Эрүүл мэндийн сайдын 2006 оны  
“Эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйн хэм хэмжээ,  
ёс зүйн хорооны дүрэм, журам батлах тухай”

135 дугаар тушаалын долоодугаар хавсралт

**Тусламж үйлчилгээнээс татгалзсан тухай хуудас**  
(Өвчтөний түүх/иргэний эрүүл мэндийн дэвтэрт хавсаргана)

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ \_\_\_\_\_ ОВОГТОЙ \_\_\_\_\_ би эмнэлгийн  
тусламж үйлчилгээнээс татгалзах нь ямар үр дагавартай болох тухай мэдээллийг  
эмчээсээ авсан боловч уг эмчилгээ үйлчилгээнээс ТАТГАЛЗАЖ БАЙНА.

**Эмнэлгийн тусламж үйлчилгээнээс татгалзаж буй шалтгаан:**

.....  
.....  
.....

Эмнэлгийн тусламж үйлчилгээнээс татгалзалснаар миний биед гарч болох  
хүндрэлүүдийн талаар дараахи **МЭДЭЭЛЛИЙГ БИ АВСАН.**

.....  
.....  
.....

- Дээр дурьдсан хүндрэлийн жагсаалт нь бүрэн бус гэдгийг **БИ ОЙЛГОЖ БАЙГАА** бөгөөд хэрвээ би хүссэн тохиолдолд нэмэлт мэдээлэл авч болно гэдгийг **МЭДЭЖ БАЙНА.**
- Эмнэлгийн тусламж үйлчилгээнээс татгалзсанаас гарч болох үр дагаварт эмчлэгч эмч, эмнэлгийг буруутгахгүй.

Үйлчлүүлэгчийн гарын үсэг \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /  
огноо \_\_\_\_\_ он \_\_\_\_\_ сар \_\_\_\_\_

**Үйлчлүүлэгч гарын үсэг зурах эрх зүйн чадамжгүй бол:**

Асран хамгаалагч/ харгалзан дэмжигчийн  
гарын үсэг \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /  
нэр \_\_\_\_\_

Үйлчлүүлэгчтэй ямар холбоотой эсэх \_\_\_\_\_  
огноо \_\_\_\_\_ он \_\_\_\_\_ сар \_\_\_\_\_

Үйлчлүүлэгч эрх зүйн чадамжгүй байгаа шалтгаан:

Насанд хүрээгүй  Ухаангүй   
Сэтгэцийн эмгэгтэй  Бусад (тайлбарлана уу)

**Хэрэв жирэмсэн тохиолдолд:**

Миний эхнэр дээрхи эмчилгээ үйлчилгээнээс татгалзсаныг би зөвшөөрч байна.  
Нөхрийн гарын үсэг \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

нэр \_\_\_\_\_  
огноо \_\_\_\_\_ он \_\_\_\_\_ сар \_\_\_\_\_

Хэрэв асран хамгаалагч/харгалзан дэмжигч/ нөхөр нь зөвшөөрөөгүй бол  
тайлбарлана уу:

.....  
.....  
.....

Энэхүү зөвшөөрлийн хуудсыг 2 хувь үйлдсэн болно.

Хавсралт 7  
Эрүүл мэндийн сайдын 2006 оны  
"Эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйн хэм хэмжээ,  
ёс зүйн хорооны дүрэм, журам батлах тухай"  
135 дугаар тушаалын зургаадугаар хавсралт

## ӨӨРИЙН ХҮСЭЛТЭЭР ЭМНЭЛГЭЭС ГАРАХ ТУХАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС (Өвчтөний түүхэнд хавсаргана)

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ би \_\_\_\_\_ эмчийн  
зөвшөөрсөн хугацаанаас өмнө эмнэлгээс гарах нь эмчлэгч эмч болон эмнэлгийн  
удирдлагын зааврыг дагаж мөрөөдгүй гэдгийг ойлгож байна.

Миний эмнэлгээс гарч буй шалтгаан:

-----  
-----  
-----

Энэ мөчид эмнэлгээс гарсанаар миний биед гарч болох хүндрэлүүдийн талаар  
дараах **МЭДЭЭЛЛИЙГ БИ АВСАН БОЛНО.**

-----  
-----  
-----

- Дээр дурьдсан хүндрэлийн жагсаалт нь бүрэн бус гэдгийг **БИ ОЙЛГОСОН**  
бөгөөд хэрвээ би хүссэн тохиолдолд нэмэлт мэдээлэл авч болно гэдгийг  
**МЭДЭЖ БАЙНА.**
- Энэ мөчид эмнэлгээс гарч, тусламж үйлчилгээ зогссоноос болж гарах үр  
дагаварт эмчлэгч эмч, эмнэлгийг буруутгахгүй.

Үйлчлүүлэгчийн гарын үсэг \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

огноо \_\_\_\_\_ он \_\_\_\_\_ сар \_\_\_\_\_

Үйлчлүүлэгч гарын үсэг зурах эрх зүйн чадамжгүй бол:

Асран хамгаалагч/ харгалзан дэмжигчийн  
гарын үсэг \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

нэр

Үйлчлүүлэгчтэй ямар холбоотой эсэх \_\_\_\_\_

огноо \_\_\_\_\_ он \_\_\_\_\_ сар \_\_\_\_\_

Үйлчлүүлэгч эрх зүйн чадамжгүй байгаа шалтгаан:

Насанд хүрээгүй  Ухаангүй

Сэтгэцийн эмгэгтэй  Бусад (тайлбарлана уу)

### Хэрэв жирэмсэн тохиолдолд:

Миний эхнэр эмчийн зөвшөөрсөн хугацаанаас өмнө эмнэлгээс гарахыг би  
зөвшөөрч байна.

Нөхрийн гарын үсэг \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

нэр

огноо \_\_\_\_\_ он \_\_\_\_\_ сар \_\_\_\_\_

Хэрэв асран хамгаалагч/харгалзан дэмжигч/ нөхөр нь зөвшөөрөөгүй бол  
тайлбарлана уу:

-----  
-----  
-----

Энэхүү зөвшөөрлийн хуудсыг 2 хувь үйлдсэн болно.

